



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

2013

ЖИЛИЙН ТАЙЛАН

ГАРЧИГ

ӨМНӨТГӨЛ	4
ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР	
Хүний эрх	6
Хууль сахиулах үйл ажиллагаан дахь иргэний нийгмийн хяналт оролцоо	10
Шүүхийн хараат бус байдал, эрх зүйн шинэчлэлийг дэмжих нь	12
Нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах нь	13
Төрийн ил тод хариуцлагатай байдал, иргэний нийгмийн оролцоо	14
Төрийн бус байгууллагуудын төрийн үйлчилгээнд тавих хяналт, мониторинг	14
Байгаль орчны талаар мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулах нь	16
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	17
Хэвлэл мэдээллийн эрх чөлөө	20
Чөлөөт шударга сонгууль	23
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР	
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал	24
Уул уурхайн орлогыг удирдах тогтолцоог бэхжүүлэх нь	26
Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ	29
Бизнесийн орчин	33
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР	
Нийгмийн үйлчилгээний хүртээмж	36
Боловсролын үйлчилгээний хүртээмж	41
Залуучуудын оролцоог дэмжих төсөл	47
ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ, ПОРТАЛ САЙТ	48
БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР	49
АОХН-ИЙН VII ЧУУЛГА УУЛЗАЛТ - ИРГЭНИЙ НИЙГМИЙН ФОРУМ	50
САНХҮҮГИЙН ТАЙЛАН	51
АЖИЛТНУУД	55

ТОВЧИЛСОН ҮГ

АОХН	Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БХАН	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДӨЧИ	Дэлхийн өрсөлдөх чадварын индекс
ДЭЗФ	Дэлхийн Эдийн Засгийн Форум
ЗГ	Засгийн Газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИС	Их сургууль
МУИС	Монгол Улсын Их Сургууль
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага
ТАН эвсэл	Төлсөн Авснаа Нийтэл
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ХЗЯ	Хууль зүйн яам
ХХИ	Хэрэглэгчийн хүлээлтийн индекс
ХЭЗ	Хүний эрхийн зөвлөл
ЭМШУИС	Эрүүл мэндийн шинжлэх ухааны Их сургууль



ӨМНӨТГӨЛ

Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн /Соросын сан/-ийн суурин дээр 2004 онд байгуулагдсан Нээлттэй Нийгэм Форум (ННФ) 10 дахь жилийн үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд хүргэж байна. 2013 онд ардчилсан засаглалыг бэхжүүлэх чиглэлээр тодорхой ахиц дэвшил гаргахад төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн зүтгэлтнүүдтэй хамтран ажиллаж, тодорхой хувь нэмэр оруулсандаа баяртай байна.

Хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан Эрүүгийн эрх зүйн тогтолцооны шинэтгэл эрчимтэй өрнөж, хууль сахиулах байгууллагуудын эрх зүйн байдал энэхүү шинэтгэлийн үзэл санаанд нийцэн хуульчлагдаж, процессын хуулийн төслүүд боловсрогдож эхэлснийг юуны өмнө онцгойлон тэмдэглэж байна. Хүний эрхийн байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд олон нийтийн хүний эрхийн ойлголт, мэдлэг нэмэгдэн, төрийн байгууллага, төрийн албан хаагчдын хүний эрхийн мэдрэмж дээшилж, хандлагын томоохон өөрчлөлт гарлаа. УИХ-аас баталсан “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хууль нь Монгол Улсын иргэн орлоготой эсэхээс үл хамааран өмгөөлүүлэх эрхээ эдлэхэд чухал алхам боллоо.

Төрийн бодлого боловсруулах, төрийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд иргэд, иргэний нийгэм улам идэвхтэй оролцон, бодлогод дүн шинжилгээ хийх, төрийг хянах чадавх нь сайжирч байна. 2013 онд ННФ-ын аргазүйн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр 21 төрийн бус байгууллага төрийн үйлчилгээ, үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийлээ. Үүнд, төсвийн ил тод байдал, иргэдийн оролцоо, төрөөс үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмж, уул уурхай, ашигт малтмалын лиценз, ашиг орлогын мэдээллийн нээлттэй байдал зэрэг чиглэлээр мониторинг хийж, дүнг олон нийтэд хүргэжээ. Тэрчлэн, иргэний нийгмийн байгууллагууд хэд хэдэн хуулийн төсөлд санал өгч, байр сууриа илэрхийлсний дотор Гэмт хэргийн тухай, Зөрчлийн тухай, Гэр бүлийн хүчирхийллийн тухай болон Захиргааны ерөнхий хууль зэрэг хуулийн төсөлд өгсөн санал шүүмж чухал байр эзэлж байна.

Манай оронд 2005 оноос эхлэн хэрэгжиж байгаа Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын олон улсын санаачлагын хувьд 2013 он томоохон амжилтын жил байлаа. Төлсөн татвар, хураамжаа тайлагнадаг компанийн тоо 1500 болж өмнөх жилүүдээс даруй тав дахин нэмэгдсэний зэрэгцээ тайланд зөвхөн төрд төлсөн төлбөрийн хэмжээ төдийгүй уул уурхайн үйл ажиллагааны холбогдолтой мэдээлэл буюу олборлосон бүтээгдэхүүний хэмжээ, эзэмшиж буй тусгай зөвшөөрөл, байгаль орчны нөхөн сэргээлтийн мэдээлэл зэрэг салбарыг олон нийтэд илүүтэйгээр таниулсан олон асуудал нэмэгдэж тусгагдлаа.

Нийгмийн үйлчилгээний салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч, хөгжих тэгш эрхийг хангах, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр бодлогын дорвитой өөрчлөлт гарлаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн холбоо, Монголын Дауны синдромын холбоо зэрэг төрийн бус байгууллага, мөн хүний эрхийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын олон жилийн хүчин чармайлтын үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсрол, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчин шинэчлэгдэж, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллахаар тохирлоо.

2013 он ННФ-ын хувьд ч мөн онцлог жил байлаа. Бид 2014-2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөгөө хамтран ажилладаг төрийн бус болон төрийн байгууллагуудын оролцоотойгоор боловсруулж, хэрэгжүүлэх бэлтгэлээ хангалаа. Энэхүү шинэ стратегийн дагуу ирэх дөрвөн жилд манай байгууллага төрийн ил тод, хариуцлагатай байдлыг бодит болгох, улс төрийн санхүүжилтийг боловсронгуй болгох, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, хүүхэд залуучуудыг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах юм.

Бид урьдын адил иргэний нийгмийн болон төрийн байгууллагуудтай үр бүтээлтэй хамтран ажиллахыг эрхэмлэх болно. Мөн Азийн орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд анхаарч, өөрийн орны өөрчлөлт шинэчлэлийн сургамжаас хуваалцаж, нийгмийн амьдралд иргэдийн идэвхтэй оролцоог хангадаг туршлагаас нь суралцахаар төлөвлөж байна.

Манай байгууллагаас хэрэгжүүлдэг үйл ажиллагааг сонирхож, жилийн тайлантай танилцсан эрхэм уншигч Танд гүн талархал илэрхийлж, бидний үйл ажилагаанд тустай үнэтэй санал, зөвлөмж өгөхийг хичээнгүйлэн хүсье.

Гүйцэтгэх захирал П. Эрдэнэжаргал



ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР

ХҮНИЙ ЭРХ

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Монгол Улсад хүний эрхийг хөхиүлэн дэмжих, үндэсний механизмыг бэхжүүлэх нь ННФ-ын үйл ажиллагааны нэг чухал хэсэг байсаар ирсэн бөгөөд 2013 онд энэ хүрээнд хэд хэдэн үйл ажиллагааг хэрэгжүүллээ.

Манай улс 2010 онд НҮБ-ын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR)-т орж Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн 129 зөвлөмжийн 126-г хэрэгжүүлэхээр Засгийн Газар үүрэг амлалт авсан билээ. Энэхүү үүрэг амлалтын хэрэгжилтийг шаардах нөлөөллийн ажлыг Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын Форум (Хүний эрхийн ТББ-уудын Форум) -тай хамтран тасралтгүй явуулж ирлээ.

ННФ нь НҮБ-ын хүний эрхийн механизмыг ашиглан өөрийн орны хүний эрхийн нөхцөл байдлыг дээрдүүлэхэд байнга анхаарал хандуулж ажилладаг. Энэ хүрээнд НҮБ-ын хэт ядуурал ба хүний эрхийн асуудал эрхэлсэн тусгай илтгэгч Магдалена Сепулведагийн Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр хамтран ажиллав.

Хүний эрхийн үндэсний Комисс (ХЭҮК)-ын чадавхийг бэхжүүлэх нэг гол чиглэл бол эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох явдал билээ. Тиймээс ННФ-аас ХЭҮК-ын Ажлын албаны ажилтнуудтай хамтарсан уулзалт зохион байгуулж, тус Комиссын тухай хуулийг бусад орны хууль, Хүний эрхийн үндэсний байгууллагын тухай Парисын зарчимтай харьцуулсан судалгаа, олон улсын болон үндэсний мэргэжилтнүүдийн

өгсөн санал зэргийг авч хэлэлцэн, хүний эрхийн үндэсний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх хүрээнд тодорхой санал, зөвлөмж гаргалаа.



UPR - ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ШААРДАХ НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛЛАГАА

ҮР ДҮН

- Зөвлөмжийн дунд хугацааны мониторинг үнэлгээг үндэсний хэмжээнд удирдан хэрэгжүүлж, 2013 оны 3 дугаар сард холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх хамтарсан семинар зохион байгууллаа.
 - Хүний эрхийн ТББ-уудын Форумаас Зөвлөмжийн хэрэгжилтийн дунд хугацааны тайланг Олон Улсын “UPR-Info” ТББ-ын загварын дагуу бэлтгэж, илгээлээ.
 - Засгийн Газраас Зөвлөмжийн хэрэгжилтийн дунд хугацааны тайланг бэлтгэж, Хүний эрхийн зөвлөлд илгээхэд нөлөөлөх зорилго бүхий үндэсний зөвлөлдөх уулзалт санаачилж ХЭҮК, ГХЯ, ХЗЯ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2013 оны 6 дугаар сард зохион байгууллаа.
 - Хүний эрхийн ТББ-уудын Форумаас “Хүний эрхийн зөвлөлийн зөвлөмжөөс хүлээгдэж буй үр дүн, хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлт” боловсруулах ажлыг 2013 оны 9-12 сард хийж дуусгав.
 - Шийдвэр гаргах албан тушаалтны анхаарлыг Зөвлөмжийн хэрэгжилтэд хандуулах зорилго бүхий нөлөөллийн цуврал үйл ажиллагааг Олон Улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан эхлүүлээ.
- Хүний эрхийн ТББ-уудын Форумаас UPR зөвлөмжийн хэрэгжилтийн дунд хугацааны мэдээллийг бэлтгэж олон улсын байгууллагад илгээв.
 - 2013 оны 11 дүгээр сард Зөвлөмжийн хэрэгжилтийн Дунд хугацааны тайлан бэлтгэх Ажлын хэсгийг Засгийн газраас байгуулав.
 - “Хүний эрхийн зөвлөлийн зөвлөмжөөс хүлээгдэж буй үр дүн, хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлт” боловсруулагдав.

ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИЛТ ДҮГНЭЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (UPR) ГЭЖ ЮУ ВЭ?

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR – Universal Periodic Review) нь НҮБ-ын гишүүн 192 орны хүний эрхийн төлөв байдлыг 4 жил тутамд дүгнэн хэлэлцэх цоо шинэ механизм юм. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 60/251 тоот тушаалаар НҮБ-ын Хүний Эрхийн Комиссыг Хүний Эрхийн Зөвлөл болгон өөрчлөн байгуулж, “бүх гишүүн улсынхаа хүний эрхийн талаар олон улсын өмнө хүлээсэн үүрэг, амлалтын биелэлтийг олон талын үнэн бодит мэдээлэлд үндэслэн цогцоор нь дүгнэн хэлэлцүүлэх” эрх олгожээ.

UPR нь ямарваа нэг гэрээ конвенциор хязгаарлагдахгүйгээр хүний эрхийн бүхий л асуудлыг нэг дор авч хэлэлцэх боломж олгож байгаагаас гадна НҮБ-ын бүх гишүүн улсыг хамрах болсноороо хүний эрхийн бусад олон улсын механизмуудаас илүү ач холбогдолтой юм (Дэлгэрэнгүй мэдээллийг www.upr-mongolia.mn болон <http://www.ohchr.org> вэб хуудаснаас үзнэ үү.).

НҮБ - ЫН ТУСГАЙ ИЛТГЭГЧ МАГДАЛЕНА СЕПУЛВЕДАТАЙ ХИЙСЭН УУЛЗАЛТ

НҮБ-ын Тусгай элчтэй хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын хийсэн уулзалтын үеэр манай улс дахь ядуу иргэдийн нөхцөл байдлын талаар харилцан ярилцсан юм. Манай улс дахь ядуу иргэдийн нөхцөл байдал, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шилжин суурьшигсад, нүүдэлчин малчид, хөдөөгийн иргэд, ХДХВ, ДОХ-ын халдвар тээгчид, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогсад, дүрвэгсэд болон харьяалалгүй хүмүүсийн нөхцөл байдлын талаар хэлэлцүүлэг өрнөлөө. Мөн нийгэм дэх тэгш бус байдал, хүн амын тодорхой бүлэг хэсэг нь эдийн засгийн хөгжлийн гадна үлдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс, тэгш зохистой хөгжлийг хангахад Засгийн Газраас хийж буй алхмууд, ядуурлыг арилгах бодлого хөтөлбөр, төрөөс үзүүлэх эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, шударга шүүхээр шүүлгэх зэрэг ядуу хүмүүст тулгамдаж буй асуудлууд хөндөгдөв (Дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn вэб сайтаас үзнэ үү.).



Тусгай илтгэгч Магдалена Сепулведатай хийсэн иргэний нийгмийнхний уулзалт, ННФ, 2013 оны 12 дугаар сар.

ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ МЭДЛЭГ, МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭХ НЬ

Хүний эрхийн тухай ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, онолын түвшинд хөгжүүлэх, хүний эрхийн мэдрэмж, хандлагыг бүхий л салбарт гүнзгийрүүлэх зорилгоор ХЭҮК-той хамтран 2012 оноос эхлүүлсэн хүний эрхийн цуврал лекцийг үргэлжлүүллээ. 2013 онд нийтдээ зургаан лекц зохион байгуулагдаж, хүний эрхийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг гадаад, дотоодын эрдэмтэн, судлаач, төрийн байгууллагын ажилтнууд илтгэл тавилаа (Лекцийн цувралыг бүрэн эхээр нь www.forum.mn вэб сайтаас үзнэ үү.).

Хүний эрхийн чухал асуудлыг олон талын оролцоотой хэлэлцэх зорилгоор ХЭҮК-той хамтран 2013 оны 10 дугаар сараас “Хүний эрхийн тухай ярилцъя” сэдэвт өглөөний уулзалт зохион байгуулж эхэллээ. Уг уулзалт нь сар бүрийн 3 дахь долоо хоногийн Пүрэв гарагийн өглөө ННФ-ын хурлын танхимд болдог бөгөөд 2013 онд хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах, үйл ажиллагааг бэхжүүлж, хүрээг нь өргөжүүлэх, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зэрэг асуудлын хүрээнд ярилцлаа. Уулзалтад төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, оюутан залуус зэрэг нийгмийн аль ч бүлгийн хүмүүс оролцох нь нээлттэйгээс гадна хүний эрхийн асуудлаарх цаг үеийн мэдээлэл харилцан солилцох боломж оролцогчдод олддог.

Түүнчлэн, төрийн байгууллагын ажилтнуудын хүний эрхийн тухай мэдлэгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа хүний эрхэд суурилан явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалт, семинар зохион байгуулав.

ННФ-аас 2013 онд хүний эрхийн сэдвээр зохион байгуулсан үйл ажиллагааны жагсаалтыг доорх календариас харна уу.

2013 ОНД ХҮНИЙ ЭРХИЙН МЭДЛЭГ, ОЙЛГОЛТЫГ ТҮГЭЭХ ХҮРЭЭНД ЗОХИОГДСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА

I УЛИРАЛД

- Хүний эрхийн лекц: Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ ба Хүний эрх (илтгэгч: ЭМШУИС-ийн АУС-ийн тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, профессор Д.Одонтуяа)

II УЛИРАЛД

- Хүний эрхийн лекц: Улс төрийн эрх, эрх чөлөө – Сонгох, сонгогдох эрх (илтгэгч: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн зөвлөх багш, ХБНГУ-ын Бонн хотын ИС-ийн докторант, LL.M Д.Үүрцайх)
- Хүний эрхийн лекц: Европ дахь хэвлэлийн эрх чөлөө ба иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрхийн асуудал (илтгэгч: Европын комиссын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудлаарх ажлын хэсгийн гишүүн, Берлиний чөлөөт ИС-ийн профессор, Олон улсын хүний эрхийн зөвлөх Херта Дойблер Гмелин)

III УЛИРАЛД

- Хүний эрхийн лекц: Бизнесийн салбарт хүний эрхийг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих нь (илтгэгч: Дани Улсын хүний эрхийн хүрээлэнгийн хүний эрх, бизнесийн зөвлөх Нора Гоцман, Кетрин, Блох Пульсен-Хансен)
- Сургалт-семинар: ХЗЯ-ны захиалгаар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс боловсруулсан “Хууль зүйн салбарт хүний эрхийн үнэлгээ хийх аргачлал”-ыг тус яамны холбогдох ажилтнууд үйл ажиллагаандаа нэвтрүүлэх чадавхийг бэхжүүлэх сургалт

IV УЛИРАЛД

- Хүний эрхийн лекц: Тэгш эрхийн зарчим ба ялгаварлан гадуурхалтыг хориглох нь (илтгэгч: ХЗЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Хууль зүйн ухааны доктор Д.Сүнжид)
- Хүний эрхийн лекц: “Хөгжил ба Эрх чөлөө” (илтгэгч: Шүүхийн ерөнхий газрын даргын зөвлөх бөгөөд Шүүхийн судалгаа мэдээллийн төвийн захирал, Хууль зүйн ухааны доктор М.Туяа)
- Уулзалт: “Хүний эрхийн тухай ярилцъя” сэдэвт өглөөний уулзалтууд

ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХЯНАЛТ, ОРОЛЦОО

ННФ хууль сахиулах үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах чиглэлээр анхаарал хандуулж ирсэн бөгөөд энэ хүрээнд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, мониторингийн төсөлд тэтгэлэг олгох зэрэг ажлыг зохион байгууллаа. Энэ онд зохион байгуулсан эдгээр ажил нь ННФ-ын 2014-2017 онд хэрэгжүүлэх стратегид тусгагдсан хууль сахиулах үйл ажиллагаанд хяналт тавих иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болох юм.

2013 оны 11 дүгээр сард УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Женев дэх Зэвсэгт хүчний ардчилсан хяналтын төвтэй хамтран “Аюулгүй байдлын салбарын засаглалд иргэний нийгмийн байгууллагын гүйцэтгэх үүрэг” сэдэвт дугуй ширээний ярилцлага зохион байгууллаа. Уг ярилцлагад иргэний, улс төрийн эрхийн чиглэлээр ажилладаг, мөн хүүхэд, эмэгтэйчүүд, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалдаг монголын иргэний нийгмийн байгууллагын 30 гаруй төлөөлөөс гадна Киргизстан, Нидерланд, Гүрж улсуудын иргэний нийгмийн төлөөлөл



оролцсон юм. Энэхүү ярилцлагаар ардчилсан тогтолцоонд аюулгүй байдлын салбарт тавих идэвхтэй хяналтын нийтлэг шинж чанар, хөгжиж байгаа болон шилжиж буй оронд энэ чиглэлээр тулгамдаж буй асуудалд анхаарал хандуулан ярилцлаа. Мөн иргэний нийгмийн байгууллагаас явуулж буй нөлөөлөл, мониторинг, мэдлэг түгээх үйл ажиллагааны талаар яриа өрнөсний зэрэгцээ, ардчиллын институциуд, аюулгүй байдлын салбар, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, хэлэлцүүлэг хийхэд төрийн бус байгууллагуудад тулгарч буй асуудлыг авч хэлэлцлээ. Мөн тагнуулын байгууллагыг сурвалжлах чиглэлээр 25 жил мэргэшин ажиллаж байгаа Нидерландын сэтгүүлч Вил Ван дер Сахнс тагнуулын байгууллагыг сурвалжлах, тус байгууллагаас мэдээлэл авах талаарх өөрийн орны туршлагаас яриу.

2014-2017 оны стратегид туссан хууль сахиулах үйл ажиллагаанд иргэний нийгмийн үр нөлөөтэй хяналт тавих чадавхийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд зарим ажлыг эхлүүллээ. Тухайлбал, Хамтын хяналт сүлжээ (Эрхэм журам, Ёст хэм хөгжил, Олон нийтийн хөгжлийг дэмжих үндэсний төв ТББ-ууд хамтарсан) цагдаагийн байгууллагын үйлчилгээнд хүний эрх хэрхэн хангагдаж байгаад мониторинг хийх тэтгэлэг аваад ажиллаж байна. Уг сүлжээний “Цагдаагийн байгууллагын үйлчилгээн дэх хүний эрхийн хэрэгжилт” сэдэвт мониторингоор цагдаагийн байгууллагын үйлчилгээ нь иргэдийн эрх, эрх чөлөөг хүндэтгэсэн, тэдний тав тухтай үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж чадаж буй эсэхийг ажиглан судлах юм.



“Аюулгүй байдлын салбарын засаглалд иргэний нийгмийн байгууллагын гүйцэтгэх үүрэг” сэдэвт дугуй ширээний ярилцлага

Зүүн гар талаас: УИХ-ын гишүүн М.Батчимэг, ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал, Эден Коул, ДКАФ 2013 оны 11 дүгээр сар.

ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИН 2013 ОНД



Санал өгсөн хуулийн төсөл

- Гэмт хэргийн тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Зөрчлийн тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль



Хамтран ажилласан ажлын хэсэг

- Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг
- Захиргааны ерөнхий хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг



Хамтын ажиллагаа, туслалцаа



- Шүүхийн иргэний төлөөлөгчид зориулсан гарын авлага боловсруулах
- Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хууль зүйн яам, Шүүхийн ерөнхий зөвлөл, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хамтран зохион байгуулсан “Хуулийн засаглал ба шударга ёс” үндэсний чуулган

Монгол Улсын Засгийн газраас энэ онд эрх зүйн шинэчлэлийн хүрээнд олон чухал хууль шинээр эсхүл шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлсэн. Энэхүү шинэчлэлийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд аль болох олон талын оролцоог хангах, ялангуяа иргэний нийгмийн дуу хоолойг хүргэхийг зорьж төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачдыг оролцуулан хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулж гарсан санал, зөвлөмжийг холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх ажлыг шинээр эхлүүллээ. Ингэхдээ зөвхөн санал өгөх бус шинээр боловсруулсан хуулийн төслийн үзэл баримтлал, зохицуулах харилцааны талаар ажлын хэсгийн гишүүд, эрдэмтэн судлаачдаар тусгай танилцуулга, мэдээлэл хийлгүүлж үр дүнд нь хэлэлцүүлэгт оролцогчид эрх зүйн шинэчлэлийн талаар тодорхой ойлголт мэдлэгтэй боллоо. Улмаар энэ нь иргэний нийгмийг шинэчлэлийн үйл явцын гадна биш, харин илүү идэвхтэй оролцогч байх боломжийг олгож байгаа юм.

Түүнчлэн, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт гишүүнээр орж ажиллах, техникийн туслалцаа үзүүлэх, шинэчлэлийн хүрээнд зохион байгуулж буй томоохон арга хэмжээг дэмжих зэргээр эрх зүйн шинэчлэлд хувь нэмрээ оруулж байна.

ҮР ДҮН

ННФ Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг анх санаачилж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр олон жил идэвх зүтгэл гаргасны үр дүн гарч 2013 оны 7 дугаар сард УИХ-аас Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль батлагдлаа.



ХУУЛИЙН ШҮҮМЖ

ННФ хуулийн төслийн хүрээнд хийсэн хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжид тулгуурлан “Хуулийн шүүмж” бэлтгэж, цувралаар хэвлэн нийтэлж эхэллээ. 2013 онд Захиргааны ерөнхий хуулийн төсөл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийн хүрээнд дээрх цувралыг гарган бодлого боловсруулагчид, иргэний нийгмийнхэн болон олон нийтэд хүргээд байна.

НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭН ХАМГААЛАХ НЬ

ННФ-ын “Нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах нь” хөтөлбөрийн амжилт, сургамж, цаашид анхаарах зүйлийн талаар энэ оны 9 дүгээр сард төрийн бус байгууллага, өмгөөлөгч, хуульчдын оролцоотойгоор хэлэлцлээ. Энэхүү хэлэлцүүлгээс өмгөөлөгчдийг сургах, “Стратегийн өмгөөлөл” гарын авлагыг шинэчлэн хэвлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зэргээр хамтран ажиллах хэрэгцээ шаардлага байгааг оролцогчид онцолсон юм. Тиймээс Монгол Улсад нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах асуудал дөнгөж үүсч хөгжиж байх үед гарсан “Стратегийн өмгөөлөл” гарын авлага шинэчлэн боловсруулж, олны хүртээл болгоод байна.

Нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалахад иргэний нийгмийн байгууллагуудын идэвх санаачлагыг дэмжиж, жил бүр тодорхой тооны төсөл санхүүжүүлж байна. Мөн шинээр байгуулагдсан Хуульчдын холбооны дэргэдэх Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны асуудал эрхэлсэн Хороотой нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр хамтын ажиллагаа эхлүүлээ.



НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР

Тэтгэлэг, сургалт

- 2013 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврийн хүртээмж, дотуур байрны хүүхэд хамгааллын асуудлаар стратегийн өмгөөлөл, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын чиглэлээр мониторингийн тэтгэлэг олгов.
- Нийтийн эзэмшлийн газрын маргаан, ахуйн хог хаягдлын менежмент, байгаль орчны хууль тогтоомжийн асуудлаар эхлүүлсэн төслүүд үргэлжиллээ.
- Өмгөөлөгч, практик ажилтнуудад зориулан “Стратегийн өмгөөлөл” сэдэвт сургалт зохион байгуулав.



ННФ-аас 2006 онд нийтийн хүртээл болгосон “Стратегийн өмгөөлөл” гарын авлага нь энэ сэдвээрх монгол хэлээр гарсан анхны эх сурвалж байсан юм. Энэ удаа уншигч, хэрэглэгчдийн хүсэлт, стратегийн өмгөөллийн хөгжил, ахиц дэвшилтэй холбогдуулан уг гарын авлагыг дахин боловсрууллаа. Гарын авлага нь стратегийн өмгөөллийн тухай ойлголт, арга зүйн зөвлөмж болон хэрэг судлал гэсэн бүлгүүдтэй.

Энэхүү гарын авлагыг эрдэмтэн, судлаач, өмгөөлөгч, практик ажилтнуудын өргөн оролцоотойгоор боловсруулж монголын хэрэг судлал, туршлагыг түлхүү оруулж, гадаад, дотоодын гол эх сурвалж, хэргүүдийг ишлэл болгов.

ТӨРИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ХЯНАЛТ, МОНИТОРИНГ

ННФ-аас “Төрийн бус байгууллагын мониторинг” тэтгэлэгт хөтөлбөрийг 2013 онд найм дахь жилдээ зарлан хэрэгжүүллээ. Төрийн үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахад иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн бус байгууллагуудын мониторинг хийх чадавхийг бэхжүүлэх зорилготой уг хөтөлбөрт Улаанбаатар хотын 11, хөдөө орон нутгийн 10, нийт 21 төрийн бус байгууллага шалгарч, дараах чиглэлээр мониторингийн төсөл хэрэгжүүлж байна:

- Төсөв
- Төрийн хариуцлага, ил тод байдал
- Төрийн болон нийгмийн үйлчилгээ
- Хүний эрх
- Уул уурхай, газрын тос, байгалийн хийн салбар.

Энэ жилийн мониторингийн төслүүд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль батлагдсанаас хойш хоёр жилийн дараа хэрэгжиж байна. Эрх зүйн орчин бүрдээд тодорхой хугацаа өнгөрсөн хэдий ч мэдээллийн ил тод байдал хангалтгүй хэвээр байгааг мониторинг хэрэгжүүлж буй байгууллагуудаас авсан судалгаа харуулж байна. Судалгаанд хамрагдсан 17 байгууллагын 70 гаруй хувьд нь мэдээлэл авахад их бага хэмжээний хүндрэл учирчээ (тоон үзүүлэлтийг графикаар харуулав).

Мониторинг хийхээр ажиллаж буй ТББ-уудад төрийн байгууллагаас шаардлагатай мэдээлэл авахад тохиолдож буй түгээмэл бэрхшээлүүдээс дурдвал мэдээллийг хуулийн хугацаанд өгөхгүй удаах, “өөр хүнээс асуу” гэж нэг нэгэн рүүгээ явуулж чирэгдүүлэх, мэдээлэл өгөх мэрэгжилтэн эзгүй тохиолдолд түүнийг орлож мэдээлэл өгөх хүн байхгүй байх, хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгөхгүй байх зэрэг болно. Түүнчлэн, хуулийн дагуу мэдээлэл хүсэгч мэдээлэл авах болсон шаардлага, үндэслэлээ тайлбарлахгүй байх эрхтэй боловч заавал тайлбар тавьж, тухайн байгууллагын дарга нь зөвшөөрөл өгсөний дараа хүссэн мэдээллийг олгосон хэд хэдэн тохиолдол гарчээ. Мөн дээд шатны байгууллагаас мониторинг хийж буй төрийн бус байгууллагад мэдээлэл өгөхийг хориглосон албан бичгийг доод шатны байгууллагуудад илгээсэн тохиолдол гарсан бөгөөд нэлээдгүй хүчин чармайлт

гаргасны үр дүнд мэдээлэл өгөхийг зөвшөөрсөн боловч санхүүгийн тайланг үзүүлэхгүй, өгсөн мэдээллээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээхгүй байх болзол тавьсан байна. Үүнээс гадна зарим төрийн бус байгууллага хүссэн мэдээллээ авч огт чадаагүй байна. Мэдээлэл өгөхөөс татгалзсан шалтгааныг байгууллагын нууц болон тухайн мэдээлэл байхгүй гэж холбогдох төрийн байгууллагаас тайлбарлажээ.



Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд төрийн байгууллага өөрийн үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулж, тухай бүр шинэчилж байхаар зохицуулсан юм. Гэвч цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж буй мэдээлэл нь хэт ерөнхий, хуучирсан байх явдал нэлээдгүй байгааг судалгаанд оролцсон төрийн бус байгууллагууд илэрхийлжээ.

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн хэрэгжилт ийнхүү хангалтгүй байгаа нь төрийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, төрөөс гаргаж буй тогтоол шийдвэр, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг сайжруулахад чиглэсэн төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа юм. Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэхэд төрийн бус байгууллагын мониторинг чухал үүрэгтэйг харгалзан ННФ-аас төрийн бус байгууллагуудын энэхүү үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжих болно.

2013 онд мониторингийн хөтөлбөрт шалгарсан төрийн бус байгууллагуудын жагсаалтыг Санхүүгийн тайлангаас, хэрэгжүүлж буй төслүүдийн талаарх мэдээллийг холбогдох хөтөлбөрийн тайлангаас харна уу.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС МЭДЭЭЛЭЛ АВАХАД ХҮНДРЭЛ ГАРСАН УУ?

(Асуулгад 17 ТББ оролцсон.)



БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ ИРГЭДИЙН ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ НЬ

Хүний үндсэн эрхүүдийн нэг болох мэдэх эрх хэрэгжих суурь нөхцөл нь мэдээлэлтэй байх явдал юм. ННФ төрийн байгууллагаас мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулах, улмаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах явцад иргэд бүрэн утгаараа оролцох боломжийг бүрдүүлэхэд байнга анхааран ажиллаж ирсэн билээ.

Байгаль орчны мэдээллийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй болгоход чиглэсэн бусад орны сайн туршлагыг судалж, улмаар өөрийн оронд нэвтрүүлэх бэлтгэл ажил хийгдлээ. 2013 оны 5 дугаар сард ННФ-ын дэмжлэгтэйгээр Монголын иргэний нийгмийн болон төрийн байгууллагын төлөөлөл Индонези Улсад амжилттай хэрэгжсэн “Байгаль орчны талаар мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулах нь” төслийн үр дүнтэй танилцлаа. Энэхүү төслийг Монгол Улсад хэрэгжүүлэх санал боловсруулж, 2014 оноос эхлүүлэхээр ажиллаж байна.

Манай улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа байгаль орчны 10 багц хуульд байгаль орчны талаар үнэн зөв мэдээлэл авах иргэдийн эрхийг бүрэн хуульчлаагүй бөгөөд холбогдох төрийн байгууллагуудын бараг тэн хагас нь байгаль орчны мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах үүрэг хүлээгээгүй байна. Мэдээлэл нээлттэй байлгахыг хуулиар даалгасан тохиолдолд хэн, ямар мэдээллийг, хэзээ, ямар аргаар нийтэд хүргэх талаар зохицуулалт байхгүй, мөн нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг хуульд тусгалгүй үлдээжээ. Иймээс дээрх дутагдлыг арилгахын тулд “Байгаль орчны талаар мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулах нь” төслийн хүрээнд байгаль орчны мэдээллийн ил тод байдлын стандарт боловсруулж, батлуулахад чиглэсэн нөлөөллийн ажил явуулахаар төлөвлөж байна. Энэ хүрээнд байгаль орчны салбарын мэдээллийн ил тод байдал, иргэдийн оролцооны эрх зүйн орчинг үнэлэх, нийтэд ил болгосон мэдээлэл иргэдийн хэрэгцээг хангаж байгаа эсэхийг судлахаас гадна байгаль орчны мэдээлэл ашиглан хүрээлэн буй орчноо сайжруулахад нь иргэдэд дэмжлэг үзүүлэх ажлууд хийгдэх юм.

Төслийг Нээлттэй нийгэм сангуудын Хүний Эрхийн Санаачлага хөтөлбөрийн хүрээнд Хөвсгөл далайн эзэд, Хүний эрх хөгжил төв, Ил тод байдал сан, Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн зэрэг байгаль орчныг хамгаалах, төрийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд Дэлхийн нөөцийн хүрээлэнгийн арга зүйн туслалцаатайгаар хэрэгжүүлэх юм.



Зүүн гар талд: “Иргэдийн байгаль орчны талаар мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь” сэдэвт бүсийн чуулга уулзалтын төлөөлөгчид (Монгол Улсаас иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл болон БОНХЯ-ны Хяналт Мониторингийн газрын дарга Л.Батжав нар оролцов.)

Баруун гар талд: Бантен мужийн Сучунг гол. Голын эргээрх үйлдвэрүүд өдөрт 43,044.35 т³ бохир ус хаяснаас усан дахь биологийн төрөл зүйл цөөрч, агаар бохирдон, тариалангийн талбай нь хуурайшжээ. Иргэд газраа зараад тосгоноос нүүхийг хүссэн ч газрыг нь маш хямд (0.22-1.11 ам.доллар) үнэлсэн байна. Дээрх төслийн хүрээнд өргөдөл, хүсэлт гаргаснаар олон чухал мэдээллийг ил болгосны нэг нь шингэн хаягдлын Үндэсний чанарын стандартад зарим химийн элементийг хамруулаагүй явдал байсан.

ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах нь жил бүр өсөн нэмэгдэж буй төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, захиран зарцуулагчдын хариуцлагыг дээшлүүлэх, төсвийн үйл явцад иргэдийн оролцоог хангахад нэн чухал үүрэгтэй билээ. Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль 2011 оноос, Төсвийн тухай хууль 2013 оноос тус тус хэрэгжиж эхэлснээр төсвийн ил тод, нээлттэй байдал болон иргэдийн оролцоог хангах эрхзүйн орчин бүрдэж эхэлсэн боловч тодорхой заалтуудын хэрэгжилтэд анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна. Ялангуяа төсвийн төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн төсвийн эрх мэдэл нэлээд нэмэгдэж байгаа нөхцөлд орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах нь чухал.

ННФ 2004 оноос улсын болон орон нутгийн төсвийн мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, иргэдийн оролцоог хангах чиглэлээр ажиллаж ирлээ. 2011 онд анх удаа орон нутгийн төсвийн ил тод байдлын түвшинг тодорхойлох судалгаа хийхэд төсвийн ил тод, нээлттэй байдал хангалтгүй байгаа нь харагдсан юм. 2013 онд орон нутгийн төсвийн баримт бичиг, төсвийн үйл явцын ил тод байдлын хоёрдахь судалгааны ажлаа эхлүүлээд байна. Судалгаагаар 21 аймаг, нийслэл хотын төсвийн ил тод байдлыг үнэлэх бөгөөд төсвийн мэдээллийг орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын судлаачид цуглуулж байна. Төсвийн мэдээлэл цуглуулж эхлэхээс өмнө орон нутгийн судлаачдад арга зүйн сургалт зохион байгуулж, удирдамж өгч ажиллалаа. Уг үнэлгээг 2013 онд “Иргэд төсвөө хянана” төрийн бус байгууллагын сүлжээнээс “Орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын загвар стандарт”-ыг боловсруулах ажлын хүрээнд гаргасан төсвийн эрхзүйн зураглалыг үндэслэн хийж байгаа бөгөөд ирэх оны эхээр үр дүнг олон нийтэд танилцуулах юм. Судалгааны дүн нь төсвийн ил тод байдал, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар бодлого боловсруулагчид, орон нутгийн удирдлага, олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд хувь нэмэр оруулахын зэрэгцээ орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын ажилтнуудын төсвийн эрхзүйн мэдлэг дээшлэх ач холбогдолтой юм.



*Төсвийн мэдээлэл цуглуулах арга зүйн сургалт, 2013 оны 11 дүгээр сар.
Зүүн гар талд: Орон нутгийн төсвийн мэдээлэл авах судлаачид
Баруун гар талд: “Иргэд төсвөө хянана” сүлжээний зохицуулагч Д.Цэрэнжав, багш Л.Отгонтуяа*

Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай болон Төсвийн тухай хуулийн ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангах заалтуудын хэрэгжилт сэдвээр Архангай аймгийн Хөдөөгийн хөгжлийн ундарга нийгэмлэг, Ховд аймгийн Хэвлэлийн хүрээлэнгийн баруун бүсийн мэдээлэл сургалтын төв, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн холбооны Төв аймаг дахь салбар ТББ-ууд мониторингийн тэтгэлгийн хүрээнд ажиллан үр дүнгээ гаргаад байна.



ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ МОНИТОРИНГИЙН ДҮНГЭЭС

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтын судалгаагаар 16 сумын 1300 гаруй иргэний 50 хувь нь сангийн талаар мэдээлэлгүй (ялангуяа сумын төвөөс алс амьдарч буй иргэдэд мэдээлэл хүрдэггүй) байгаа нь харагдсан юм.

Ховд аймгийн Сум хөгжүүлэх сангийн мониторингийн төслийн дүнгээс

Засаг даргын Нөөцийн сангийн хөрөнгийг ихэнх тохиолдолд нэг удаагийн шинжтэй хүлээн авалт, хүндэтгэлийн арга хэмжээ, гадаад томилолт зэрэг үйл ажиллагаанд зарцуулж байна.

Нөөцийн сангийн дэргэдэх Зөвлөлийн шийдвэрт үндэслэн Засаг дарга захирамж гаргах ёстой атал уг тогтолцоо хэрэгждэггүй ба уг Зөвлөл нь тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй байна.

Архангай аймгийн Засаг даргын нөөцийн сангийн мониторингийн дүнгээс

Төв аймгийн Батсүмбэр, Баяндэлгэр, Баянчандмань сумдын орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоо хангалтгүй байна. Тухайлбал, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийг тодорхойлохоор санал асуухад Баяндэлгэр, Баянчандмань сумдад иргэдийн 13-44 хувь нь оролцсон байна. Харин Баяндэлгэр суманд иргэдийн 79 хувь нь оролцжээ.

Төсвийн талаарх олон нийтийн санал асуулгыг холбогдох журамд 3 хэлбэрээр (бүлгийн ярилцлага, асуулгын хуудас, цахимаар) авна гэж заасан боловч айл өрх бүрийг хамарч чадах асуулгын хуудсаар авалгүй, хөдөө орон нутагт төдийлөн дэлгэрээгүй цахим хэлбэрийг ашигласнаас гадна зөвхөн багийн иргэдийн Нийтийн Хуралд оролцсон иргэдээс санал авч байгаа нь харагдав.

Төв аймгийн зарим сумын иргэдийн оролцооны мониторингийн дүнгээс

2013 онд “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээний үйл ажиллагааг дэмжиж ажиллав. ННФ-аас дэмжсэн тус сүлжээний энэ онд хийсэн гол ажил нь www.tusuv.mn вэб сайтын мэдээллийн шинэчлэлт байв. Уг сайтад сүлжээний гишүүн байгууллагуудын ажиглалт, мониторингийн явцад олж авсан төсвийн холбогдолтой шинэ мэдээллийг тогтмол байршуулж олон нийтэд хүргэж ирлээ. www.tusuv.mn нь Сангийн яамнаас эрхэлдэг www.iltod.gov.mn -ийн дараа орох төсвийн мэдээллээр дагнасан хоёрдахь том вэб сайт болж хөгжөөд байна.

Уг цахим хуудсыг Facebook-ийн My Budget зэрэг нийгмийн сүлжээтэй холбож төсвийн мэдээлэл цуглуулах, харилцан солилцох, сурталчлах, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах талбар болгон ашиглаж байна. Мөн нийслэлийн гурван дүүрэг, гурван аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаар иргэдийн санал авах хэлэлцүүлэгт оролцож, баримтжууллаа. Үүнээс гадна Засгийн газрын тусгай сангуудын хөрөнгийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгох кампанит ажил явуулж, энэхүү ажлын явцад нээлттэй болгосон баримт мэдээлэл, тайлан, тайлбар зэргийг www.tusuv.mn вэб сайтад байршуулжээ.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Улсын болон орон нутгийн төсвийн ил тод, хариуцлагатай байдал, иргэдийн оролцоог сайжруулах үйл ажиллагааны зэрэгцээ ННФ улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд нэн чухал үүрэгтэй эрчим хүчний салбарын төсөв, санхүүгийн ил тод, хариуцлагатай байдлыг үнэлэх чиглэлээр ажиллаж эхлээд байна. Монгол Улсын эрчим хүчний салбарын үйл ажиллагааг бараг бүхэлд нь төр хариуцан энэ салбар улсын төсвөөс санхүүждэг бөгөөд сүүлийн жилүүдэд асар их хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжаар тэтгэгдэж иржээ. Иймд тус салбарын бодлого төлөвлөлт, хэрэгжилт нь хариуцлагатай, иргэдэд ил тод байх нь чухал юм. ННФ-аас судлаачидтай хамтран 2012 онд Монгол Улсын эрчим хүчний засаглалын үнэлгээ хийсэн билээ. Эрчим хүчний салбарын засаглалыг сайжруулах шаардлагатай байгаа нь судалгааны дүнгээс харагдсан тул цаашид эрчим хүчний салбарын засаглалыг сайжруулах чиглэлээр ажиллахаар төлөвлөж, 2013 онд Дэлхийн нөөцийн институтээс зохион байгуулсан Эрчим хүчний засаглалын санаачлагын олон улсын түншүүдийн хуралд оролцож, энэ чиглэлээр хэрэгжүүлж буй олон улсын туршлагатай танилцлаа.



*Эрчим хүчний засаглалын санаачлагын олон улсын түншүүдийн хуралдаанд оролцогчид
Кэйп Таун, ӨАБНУ
2013 он*

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

ӨӨРӨӨ МЭДЭЭЛЭХ СИСТЕМ SELF ALERTING SYSTEM



Өөрөө мэдээлэх системд бүртгүүлэх
www.globeinter.org.mn

Монгол Улс *Freedom House* олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг хэвлэлийн эрх чөлөөний индексээр 2013 онд 197 орноос 74-т жагсаж, 11 дэх жилдээ хэвлэлийн хагас эрх чөлөөтэй орны тоонд орлоо. Засгийн газар, Харилцаа холбооны зохицуулах хорооноос энэ жил гаргасан “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн тухай тогтоол болон Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам нь цахим ертөнц, цахим мэдээллийн хэрэгслээр үзэл бодлоо илэрхийлэх эрхийг боогдуулах, улмаар хэвлэлийн эрх чөлөөнд сөргөөр нөлөөлсөн явдал болсон юм.

ННФ хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг бэхжүүлэх зорилгоор Глоб Интернэшнл Төвийн 2015 он хүртэл хэрэгжих “Хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” төслийг үргэлжлүүлэн дэмжлээ. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх, бие даасан байдлыг хамгаалах нь хэвлэлийн эрх чөлөөг бүрэн утгаар нь бэхжүүлэхэд чухал нөлөөтэй юм. Глоб Интернэшнл Төв хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн мэргэжлийн эрхэд халдаж буй тохиолдлуудыг онлайн мониторингийн өөрөө мэдээлэх “self-alerting” системээр дамжуулан бүртгэж олон нийтэд түгээх, эрх нь зөрчигдсөн сэтгүүлчдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх, өмгөөлөгчдөд сэтгүүлчдийг өмгөөлөх чадвар эзэмшүүлэх ажлуудыг хийж байна.

2013 онд онлайн мониторингийн системд 22 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой 35 зөрчил бүртгэгдсэний дотор шүүмжлэлт нийтлэл бичсэнийх нь төлөө айлган сүрдүүлэх, нийтлэл/нэвтрүүлгийг хориглох, эсвэл хориглохыг завдах зэргээр цензур тогтоох, нууц эх сурвалжаа илчлэхийг албадах болон Эрүүгийн хуулийн гүтгэх, доромжлохтой холбоотой зүйл заалтыг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эсрэг ашиглах зөрчлүүд нэлээдгүй гарчээ.

Өмнөх жилүүдтэй харьцуулахад зөрчлийн тоо буураагүй бөгөөд сэтгүүлчид цаашид учирч болзошгүй дарамт, заналхийллээс болгоомжилж, өөрсдийнх нь эрх зөрчигдөж байгаа талаар тэр болгон мэдээлдэггүй нь төслийн явцад ажиглагдсан юм. Нөгөөтэйгүүр, өөрт нь тохиолдож буй бэрхшээлийг хэвийн зүйл мэт хүлээн



Зөрчил мэдээлэх хуудас
www.globeinter.org.mn


авах, “self-alerting” системийн талаар мэдээлэл аваагүй болон бусад шалтгааны улмаас зөрчлийг бүртгүүлдэггүй байна. Тиймээс сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчлийн бодит тоо дээр дурдсан үзүүлэлтээс давсан байх үндэслэлтэй юм.

Сэтгүүлчдийн эрхийг зөрчсөн этгээдэд эсэргүүцлийн захидал илгээж, зөрчлийн тухай мэдээллийг дотоодын болон олон улсын сүлжээгээр түгээж ажилласны зэрэгцээ мэргэжлийн эрх нь зөрчигдсөн 12 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад эрх зүйн зөвлөгөө өгч, хоёр сэтгүүлчид өмгөөллийн туслалцаа үзүүлэв.

Хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлээр хуульч, өмгөөлөгчдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд энэ оны 10 дугаар сард Орхон, Дархан-Уул, Булган, Өмнөговь, Хөвсгөл, Сэлэнгэ аймаг болон Улаанбаатар хотын 11 хуульч, өмгөөлөгчийг хамруулан сургалт зохион байгуулжээ. Сургалтын үеэр дотоодын хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, олон улсад мөрдөж буй хэм хэмжээ, сэтгүүлчдийг өмгөөлөх онцлог тактикийн талаар мэдээлэл өгсөн бөгөөд оролцогчид тухайн орон нутагт мэргэжлийн эрхийн зөрчилтэй тулгарсан дор хаяж нэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчийн хэргийг өмгөөлөхөөр болсон байна.

БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЙН ТОО

(Асуулгад 17 ТББ оролцсон.)



Бүртгэгдсэн зөрчлийн 70 гаруй хувь нь хөдөө орон нутагт, сэтгүүлчдийн эрхийг зөрчигчдийн 64 хувь нь төрийн өндөр албан тушаалтан болон төрийн албан хаагчид байв.



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГА, СЭТГҮҮЛЧИЙН ЭСРЭГ ГАРСАН ЗӨРЧИЛ

- Орхон аймгийн “Нар туссан цаг” сонины 2013 оны 12 дугаар сарын 6-ны дугаарт тус аймгийн Ардчилсан холбооны үйл ажиллагааны талаар шүүмжлэлт нийтлэл хэвлэгдсэний дараа сонины редакцид тус холбооноос мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг шаардсан захидал ирүүлжээ. Сонины редакц Глоб Интернэшнл Төвөөс эрх зүйн зөвлөгөө авсны дагуу аймгийн Ардчилсан холбооны албан бичигт хариу явуулж, тухайн асуудлаар байр сууриа илэрхийлсэн нийтлэл гаргасны үр дүнд аймгийн Ардчилсан холбооноос мэдээллийн нууц эх сурвалж шаардсан үйлдлээ зогсоожээ.
- “Өдрийн шуудан” сонины 2012 оны 11 дүгээр сарын 9-ний дугаарт “Дугаарын бизнес дундраагүйгээр барахгүй илүү нарийн, илүү цадигүй болон хөгжиж байна” гарчигтай нийтлэл бичсэн сэтгүүлчид тухайн үеийн Авто тээврийн газрын хэлтсийн дарга эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Сүхбаатар дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Энэ хэрэгт холбогдсон сэтгүүлчид тухай бүр зөвлөгөө өгч, өмгөөллийн туслалцаа үзүүлж ажилласны үр дүнд 2013 оны 6 дугаар сард болсон анхан шатны шүүх хурлаар сэтгүүлчийг цагаатгажээ. Гэвч хохирогч нийслэлийн давж заалдах шатны шүүхэд өргөдөл гаргасны дагуу 9 дүгээр сард хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах шийдвэр гаргав. Одоогоор Глоб Интернэшнл Төв уг хэргийг шүүхээр шийдвэрлэх явцад мониторинг хийж байна.

“ҮГЭЭ ХЭЛЭХЭЭС ҮЛ ЭМЭЭХ НЬ: ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БҮХИЙ Л ХЭРЭГСЛЭЭР ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ НЬ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр 5 дугаар сарын 1-нийг тохиолдуулан “Үгээ хэлэхээс үл эмээх нь: Хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгслээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах нь” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав. Мөн энэ өдрийг угтаж Глоб Интернэшнл Төв, Монголын сэтгүүлчдийн эвлэл, Монголын өдөр тутмын сонинуудын холбоо, Монголын сонины холбоо, Монголын телевизүүдийн холбоо, Монголын сайтын холбоо болон Монголын хэвлэлийн хүрээлэн хамтраад УИХ болон Засгийн газарт хандаж уриалга гаргасан юм. Уг уриалгад интернэтийн цензурыг зогсоох, сэтгүүлчийн мэдээллийн нууц эх сурвалжаа хамгаалах, мөн үзэл бодлоо илэрхийлэхдээ иргэн хүн нэрээ нууцлах нь түүний хувийн нууцын салшгүй хэсэг болохыг хүлээн зөвшөөрч хуульчлах, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хараат бус байдлыг хангахад чиглэсэн бусад нэмэлт өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид тусгах зэрэг саналуудыг оруулжээ. Цаашид “Хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” төслийн хүрээнд дээрх уриалгад дэвшүүлсэн санал, санаачилгыг ажил хэрэг болгоход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулахын сацуу сэтгүүлчдэд эрхийг нь ухуулан таниулах болон хариуцлагатай хэвлэл мэдээллийн талаарх ойлголтыг хэвшүүлэх сургалтууд зохион байгуулахаар төлөвлөж байна. Төслийн дэлгэрэнгүй тайланг сонирхвол www.globeinter.org.mn хаягаар орж үзнэ үү.



Зүүн гар талаас хэлэлцүүлэгт оролцогчид, Хэвлэлийн Хүрээлэнгийн Судалгааны албаны дарга Г.Гүнжидмаа ННФ, 2013 оны 5 дугаар сар.

ЧӨЛӨӨТ ШУДАРГА СОНГУУЛЬ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зургаа дахь удаагийн сонгуулийн дүнг 2013 оны 6 дугаар сард “Сонгуулийн автоматжуулсан системийн тухай” хуулийн дагуу автомат төхөөрөмж ашиглан гаргалаа. Хэдийгээр уг төхөөрөмж 2012 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн дүн гаргахад ашиглагдсан ч, түүнд үл итгэх явдал улс төрийн хүчнүүд болон олон нийтийн дунд хэвээр байлаа. Шударга сонгууль явуулах нөхцлийг бүрдүүлэхэд санал тоолох автомат төхөөрөмжийн найдвартай, алдаагүй ажиллагаа чухал үүрэгтэйг харгалзаж, ННФ-аас уг системийн ажиллагаанд мониторинг хийх төслийг дэмжсэн юм.

Төслийг ННФ-ын санаачлагаар 2008 онд байгуулагдсан “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээний гишүүн, Монголын мэдээллийн хөгжлийн холбоо /МИДАС/ ТББ хэрэгжүүллээ. Тус байгууллага мөн 2012 оны УИХ-ын сонгуулийн автоматжуулсан системд мониторинг хийж, түүнийг боловсронгуй болгоход чиглэсэн зөвлөмжийг УИХ-ын даргад хүргүүлж байсан билээ. Энэ удаа автомат төхөөрөмжийг дахин туршиж үзэхийн зэрэгцээ жилийн өмнө гарсан дутагдлыг арилгасан эсэхийг хянах зорилготой байв.

Мониторингийн баг Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн гурван улс төрийн намын оролцоотойгоор сонгуулийн санал тоолох автомат төхөөрөмжийн программын ажиллагааг туршлаа.



Зүүн гар талаас: Тестийн үр дүнг алхам тутамд хэвлэсэн баримтууд; Тест хийхэд оролцсон олон улсын ажиглагчдын баг болон Сонгуулийн Ерөнхий хорооны дэргэдэх ажлын хэсгийн гишүүд; Намуудын төлөөлөл, 2013 оны 6 дугаар сар.



САНАЛ ТООЛОХ АВТОМАТ ТӨХӨӨРӨМЖИЙГ ТУРШИХ МОНИТОРИНГИЙН ДҮНГЭЭС

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлсэн намуудын оролцоотойгоор санал тоолох төхөөрөмжийг туршиж үзэхэд автоматжуулсан систем саналыг зөв тоолж байгаа нь харагдав. Гэвч, цаашид туршилтын явцад илэрсэн программын зарим дутагдлыг залруулах, эх кодыг нээлттэй болгох, түүнийг санал тоолох машинд суулгахаас өмнө намуудын төлөөллийг оролцуулан шалгах хэрэгтэйг анхаарах нь зүйтэй. Мөн шалгалтын дүнг олон нийтэд ил тод мэдээлэх, санал хураалт явагдтал программд өөрчлөлт орохгүйг баталгаажуулж намуудаас “манаач” томилох, улс төрийн нам, ажиглагч нарт санал тоолох машины

талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах, хяналтын тооллогын үр дүнгээр авах арга хэмжээг тодорхой болгож хуульчлах зэрэг алхамууд хийх шаардлагатай гэж үзэж байна.

Түүнчлэн, 2012 оны мониторингийн явцад илрүүлсэн зарим дутагдал арилаагүй байгаа нь ажиглагдав. Тухайлбал, санал тооллогын үр дүнг харуулсан хуудасны нууцлал хангалтгүй байгаа нь цаашид ч анхаарах нэг чухал асуудал хэвээр үлдэж байна. Мониторингийн дэлгэрэнгүй мэдээллийг <http://goo.gl/Inl9R> хаягаар орж үзнэ үү.




ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР

ОЛБОРЛОХ САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДАЛ

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГЫН ТАЙЛАН

ТАЙЛАН ГАРГАСАН КОМПАНИЙН ТОО



- 2012 оны тайлангаар
- Өмнөх оны тайлангаар

Тайлангаа бэлтгэн гаргасан компанийн тоо 1500-д хүрсэн нь өмнөх онуудад дээд тал нь 300-гаад компани тайлангаа гаргаж ирсэнтэй харьцуулахад дэвшил болсон.

Монгол Улс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага (ОҮИТБС)-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 2012 оны санхүүгийн жилийн тайланг нэгтгэн гаргах явцад ННФ идэвхтэй оролцлоо. ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэгт бусад иргэний нийгмийн байгууллагын хамтаар ажилласны дүнд 2012 оны тайлан гаргах үйл явцад чанарын томоохон өөрчлөлт гарлаа. Ийнхүү лиценз эзэмшигч бүр тайлан гаргадаг болсон нь ОҮИТБС-д бүх компанийг тогтмол хамруулж байх эхлэл боллоо.

Анх 2003 оноос эхлэн олон улсад хэрэгжиж ирсэн ОҮИТБС-ын дүрэм, шаардлага улам бүр чамбайрч, 2013 онд бага хурлаараа шинэчилсэн дүрэм буюу стандартаа батлахад ННФ шууд оролцож ирлээ. Тухайлбал, ННФ-ын ажилтан тус санаачлагын олон улсын зөвлөлд ажиллаж, шинэ стандартыг бэлтгэн боловсруулах, батлахад оролцлоо. Улмаар шинэ стандартыг Монгол Улсад хэрэгжүүлэх бэлтгэл ажилд Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хүрээнд, түүнчлэн бусад байгууллагатай тухайлбал, Ажлын алба, Адам Смит Интернэшнл, Орлогын Ажиглагч Хүрээлэн зэрэгтэй хамтран оролцож ирлээ. Түүний дотор Адам Смит байгууллагаас зохион байгуулсан ОҮИТБС-ын сургалт семинарт шинэ стандартыг танилцуулсан бол Орлогын Ажиглагч Хүрээлэнтэй хамтран иргэний нийгэмд зориулан шинэ стандартыг танилцуулсан уулзалт сургалт зохион байгуулав.



ОУИТБС - ЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН МОНИТОРИНГИЙН ДҮНГЭЭС

Улсын хэмжээнд тайлангаа гаргах компаниудын тоо эрс нэмэгдсэн сайн үзүүлэлт байгаа ч орон нутагт аж ахуйн нэгжүүд тайлангаа гаргахгүй, гаргасан тайлангаа олон нийтэд мэдээлэхгүй байх явдал гарсаар байгааг “Ногоон тэс” ТББ-ын хийсэн мониторингийн дүн харуулж байна. Тухайлбал, 2013 оны байдлаар Завхан аймагт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 78 аж ахуй нэгж бүртгэлтэй

байгаагаас зөвхөн 12 нь ОУИТБС-ын 2012, 2013 оны тайланд хамрагджээ. Ашигт малтмалын тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу сумын засаг дарга, түүний Тамгын газар өөрийн нутаг дэвсгэр дэх уул уурхайн үйлдвэрлэл эрхэлж буй компаниудыг ОУИТБС-д бүрэн хамруулах үүрэгтэй тул тайланг гаргуулж, олон нийтэд тайлагнахыг шаардах нь зүйтэй.

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГА ОРОН НУТАГТ

Санаачлагыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг ННФ-ын зүгээс байнга анхаарч ирсэн ба 2013 онд Орлогын Ажиглагч Хүрээлэнтэй хамтран Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Цогтцэций сумдад ОУИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэх тухай үлгэрчилсэн сургалт зохион байгуулав. Ингэхдээ эхний ээлжинд орон нутагт ОУИТБС-ыг хэрхэн хэрэгжүүлэх, тайлагналыг орон нутгийн түвшинд зохион байгуулж болох арга хэлбэрийн талаар судалж, цаашид энэ чиглэлээр ажиллах орон нутгийн удирдлага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан сургагч багш бэлтгэх сургалтад хамруулж, улмаар туршилтын хоёр удаагийн арга хэмжээ дээрх сумдад зохион байгуулагдав.

ОУИТБС-ыг олон талын буюу уул уурхайн компани, төр засаг, иргэний нийгмийн төлөөллийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлдэг ба иргэний нийгмийн гол төлөөлөл болсон “Төлсөн авснаа нийтэл эвсэл” (ТАН эвсэл)-ийн үйл ажиллагааг ННФ-ын зүгээс 2013 онд үргэлжлүүлэн дэмжлээ. Тухайлбал, тус байгууллагын гишүүдэд зориулан ОУИТБС-ын шинэ стандартыг танилцуулах сургалт явуулахаас гадна тухайн эвслийн гишүүн байгууллагууд шинэ стандартын тодорхой нөхцлүүдийг Монгол Улс хэрэгжүүлэхэд бэлтгэх ажлыг хангах судалгаа, нөлөөллийн ажиллагаа хийхэд зориулан тэтгэлэг олголоо. Үүнд уул уурхай, газрын тосны салбарын гэрээ, лицензийн мэдээллийн ил тод байдлыг ОУИТБС-ын хүрээнд хангах, төрийн өмчит компанийн талаар нэмэлт мэдээлэл тайлагнах зэрэг асуудлыг ТАН эвслийн гишүүн байгууллагууд гүйцэтгэж ирлээ. Цаашилбал, ОУИТБС-ын тухай хууль тогтоомж боловсруулах ажлын хэсэгт ННФ болон ТАН эвслийн гишүүн байгууллагууд идэвхтэй оролцож, хуулийн төсөл боловсруулахад чухал хувь нэмэр оруулаад байна.

ТАН эвслийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тус эвслийн зохицуулагч байгууллага болох Хил хязгааргүй алхам ТББ-ыг дэмжиж ирснээс гадна тус эвслийн гадаад хамтын ажиллагаанд анхаарч, Гүрж Улсад зохион байгуулагдсан “Төлснөө нийтэл” олон улсын сүлжээний бүсийн уулзалтад оролцоход нь дэмжлэг үзүүллээ.

УУЛ УУРХАЙН ОРЛОГЫГ УДИРДАХ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН САНГИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Байгалийн баялгийг зөв зохистой ашиглах чиглэлээр Монголын нийгэмд өрнөж буй мэтгэлцээн, бодлогын өөрчлөлтийг ННФ судлан шинжилж, тодорхой хувь нэмэр оруулсаар ирлээ.

2013 онд байгалийн баялгийн сан байгуулах хэлэлцүүлэгт ННФ-ын зүгээс идэвхтэй оролцлоо. Тус санг байгуулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгтэй уулзаж, хэлэлцүүлэгт оролцож, өөрсдийн байр суурийг бодлогын зөвлөмж хэлбэрээр бэлтгэн танилцууллаа. Үүнд баялгийн сангийн засаглалын асуудлыг хэрхэн зөв зохистой шийдвэрлэх талаар олон улсын шилдэг туршлагыг Монголын нөхцөл байдалд үндэслэн дүгнэж, тодорхой саналуудыг дэвшүүлсэн юм. Тухайлбал, баялгийн сангийн ил тод байдлыг хангах нь хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх үндсэн нөхцөл гэж үзсэний үндсэн дээр сангийн удирдлага, бодлого боловсруулагчдын үүрэг роль, хариуцлагыг тодорхой зааж өгөх, олон нийтэд мэдээллийг ил тод тайлагнах, шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй болгох, нийтэд болон бодлого боловсруулагчдад зориулан тайлагнаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах, баялгийн сангийн засаглал,



БАЯЛГИЙН САНГИЙН ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ЗӨВЛӨМЖӨӨС

Төлбөр, орлогын ил тод байдлын талаар:

Үндсэн хуульд “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж баталгаажуулсан. Иймээс иргэд сумынхаа нутаг дэвсгэр дэх уул уурхайн хайгуул, ашиглалтын талаар мэдэх, мэдээлэл шаардах бүрэн эрхтэй.

Гэрээний ил тод байдлын талаар:

1) “Олон нийтэд мэдээлнэ”, “нийтэд мэдээлнэ”, бүртгэлийн сан “нээлттэй байна” гэсэн заалтын дор ямар мэдээллийг хэнээс, хэнд, ямар хэлбэрээр, хэзээ, нээлттэй байлгах, олон нийтэд хэрхэн мэдээлэх процедурыг нарийвчлан тусгах шаардлагатай.

2) Олборлох салбарт байгуулах бүхий л шатны гэрээ, түүний багц дагалдах гэрээнүүд, тэдгээрт өөрчлөлт гарах бүрт олон нийтийн хэлэлцүүлэг, УИХ, ИТХ-аар нээлттэй хэлэлцдэг, олон нийтэд хүртээмжтэй хэлбэрээр мэдээлдэг байхыг хуульчлах хэрэгтэй.

3) Гэрээ хэлэлцээр байгуулах бүх үйл явц, үе шат ил тод, нээлттэй байх ёстой. Ингэснээр олон нийт

үнэн зөв мэдээлэлтэй хэлэлцэх, мэтгэлцэх замаар хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх, олборлох үйлдвэрлэлийн орлогын менежментийг сайжруулах, засаглалыг авлигаас ангид байхад хувь нэмэр оруулж чадна.

Тусгай зөвшөөрлийн ил тод байдлын талаар:

1) “Нийтэд мэдээлнэ”, бүртгэлийн сан “нээлттэй байна” гэсэн заалтуудын хүрээнд ямар мэдээллийг хэнд, ямар хэлбэрээр, хэзээ, нээлттэй болгох, олон нийтэд хэрхэн мэдээлэх процедурыг нарийвчлан тусгаж хуулийн нэр томъёоны тайлбарт оруулах шаардлагатай. Үүнд, мэдээлэл түгээх орон зай, хүлээн авагч, хэрэгслийг тодорхой зааж өгөх хэрэгтэй.

2) Лицензийн болон бүртгэлийн нэгдсэн санг цахим хэлбэрээр ил тод мэдээлэх явцад лиценз олгох, лицензийг хариуцлагатай эзэмшиж буй эсэх, түүнийг цуцлах бүхий л үйл явц, үе шат ил тод нээлттэй байх ёстой. Эзэмшигчийн болон нөлөө бүхий хувь эзэмшигчийн, удирдлагын мэдээллийг оруулах шаардлагатай.

ил тод байдлын стандартыг тогтоосон Сантиагогийн зарчмуудыг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосон юм. Түүнчлэн сангийн удирдлагыг төсвийн бодлоготой зөв уялдуулах шаардлагатай ба улс орны хөрөнгө оруулалт хийх чадвар, өнөөгийн болон хойч ирээдүй үеийн хэрэгцээ зэргийг санг байгуулахад тооцож үзэх ёстойг онцлов.

Сангийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих шаардлагатай ба тухайлбал парламент, шүүх засаглал, хяналт шалтгалтын агентлагууд, хөндлөнгийн аудитор, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллагууд болон иргэд мэдээлэл авах, хяналт тавих үйл ажиллагаанд оролцох боломж нээлттэй байх ёстой.


МОНГОЛ УЛСЫН БАЯЛГИЙН ЗАСАГЛАЛЫН ИНДЕКС

ННФ нь өөрийн түнш байгууллага болох Орлогын Ажиглагч Хүрээлэнтэй хамтран Орлогын ажиглагч индекс-2013 судалгааны үр дүнг олон нийт, холбогдох бодлого боловсруулагчдад танилцууллаа. Баялаг ихтэй 58 орныг хамарсан уг судалгаанд Монгол Улс ил тод байдлыг хангах, үр дүнтэй аудит, хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх зэрэг үзүүлэлтээр хангалтгүй оноо авсан байна. Ялангуяа уул уурхайн салбарын төрийн өмчит Эрдэнэс МГЛ компанийн наад захын тайлан мэдээлэл олон нийтэд хүрэхгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

Баялгийн засаглалын индекс нь тухайн улс орны байгалийн баялгийг удирдах засаглалыг институци ба хууль эрх зүйн тогтолцоо, тайлагналын тогтолцоо, баталгаа ба чанарын хяналт, дэмжигч орчин гэсэн дөрвөн үндсэн чиглэлээр нийт 50 үзүүлэлт ашиглан үнэлдэг, хараат бус цорын ганц судалгаа юм. 2013 оны судалгаагаар манай улс “бүрэн бус” үнэлгээ буюу 51 оноо авчээ. Монгол Улс бүтэц болон хууль эрх зүйн зохицуулалтаар өндөр оноо авсан ч, тайлагнах чиглэлээр муу оноо авсан болно. Хэсэг тус бүрийн оноог харуулбал (хэсэг тус бүрийн дээд оноо 100):

Үндсэн чиглэл	Институцийн болон эрх зүйн тогтолцоо	Тайлагналын тогтолцоо	Баталгаа ба чанарын хяналт	Дэмжигч орчин
Авсан оноо	80	39	49	48
Чиглэл бүрт эзэлсэн байр, тайлбар	9-р байр “хангалттай” буюу 80 оноо авсан нь орлогоо цуглуулах тодорхой арга механизм байгаа боловч, бодит байдалд тэр бүр хэрэгждэггүй ба тайлагнаж, мэдээлэхэд тавигддаг олон шаардлагыг тусган харуулж байна.	41-р байр Дотоодын уул уурхайн компанийн талаар төр засаг мэдээлэл багатай байсан тул “муу” үзүүлэлттэй гарсан.	37-р байр Төрийн мэдлийн уул уурхайн компанид олон нийтийн зүгээс тавих хяналт сул байгаагаас “сул” үзүүлэлттэй гарсан.	20-р байр Авилгатай тэмцэх болон төр засгийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх талаарх олон улстай харьцуулсан түвшний үнэлгээ муу байгаагаас “сул” үзүүлэлттэй гарсан.

Төрийн мэдлийн компаниудын зэрэглэлээрээ Монгол Улс авах ёстой 100 онооноос дөнгөж 20 оноо авч 45 орноос 38-д оржээ. Монгол Улсын засгийн газар стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордуудыг эзэмшихэд төрийн ашиг сонирхлыг төлөөлөх зорилгоор Эрдэнэс МГЛ компанийг байгуулсан. Тус компани санхүүгийн тайлан мэдээллээ хэвэлж, нийтлэх хууль эрхзүйн үүрэг хүлээсэн хэдий ч ямар ч санхүүгийн тайлан гаргаагүй ба компанийн үйл ажиллагааны талаар бараг мэдээллэл байхгүй байна.



ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ


УЛСЫН ТӨСВИЙН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

ННФ жил бүрийн улсын төсвийн төсөлд тойм судалгаа, шинжилгээ хийж үр дүнг нь бодлого боловсруулагчид, судлаачид, иргэд болон иргэний нийгмийн төлөөлөгчдийн дунд танилцуулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж ирлээ. 2014 оны төсвийн төсөлд хийсэн тойм судалгаанаас харахад энэхүү төсөлд орлогын тооцооллын хувьд уул уурхайн эрдэс баялгийн гол нэрийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээг өөдрөг төсөөлөх байдал хэвээр үргэлжилсэн бол зарлагын төлөвлөлтийн хувьд урсгал зардлын тэлэлт хэвээр байна.

Улсын төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын зардлыг ихээхэн хэмжээгээр бууруулсан бөгөөд төсвийн гадуурх бондын хөрөнгөөс тэдгээр хөрөнгө оруулалтыг нөхөх магадлалтай юм. Мөн Засгийн газар Чингис бондын орлогын нэлээд хэсгээр дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх магадлалтай байгаа тул энэхүү хөрөнгийг тухайн дүнгээр төсвийн хөрөнгө оруулалтын зардал хэсэгт бүртгэх нь зүйтэй юм. Цаашид бондуудын зарцуулалтын мэдээллийг зайлшгүй ил тод байлгах шаардлагатай байна.

Сангийн Яам болон Монгол Банкнаас гаргасан эдийн засгийн бодит өсөлтийн талаарх таамаглал хэт зөрүүтэй байгаа нь тойм судалгааны дүнгээс харагдаж байв. Тухайлбал, 2014 оны эдийн засгийн бодит өсөлтийг Сангийн яамны боловсруулсан төсвийн төсөлд 14.8 хувь байна гэж тооцсон бол Монголбанкны “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл”-ийн төсөлд 7.7 хувь байна гэж таамаглажээ. Иймд Засгийн газар болон Монголбанкны бодлогын уялдааг сайжруулах зорилгоор байгуулагдсан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй байна.

Төсвийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, олон нийтийг үнэн зөв хүртээмжтэй мэдээллээр хангахад Засгийн газрын зүгээс санаачлага гарган ажиллах шаардлагатай байгаа нь харагдсан юм.



ННФ-аас эрхлэн Монгол Улсын 2014 оны улсын төсвийн төсөлд хөндлөнгийн хараат бус тойм судалгаа хийлээ. Энэхүү судалгаагаар Сангийн яамнаас боловсруулсан 2014 оны төсвийн төсөлд харьцангуй богино хугацаанд тоймлон үнэлэлт дүгнэлт өгч төсвийн холбогдолтой цуврал хэлэлцүүлгийн үеэр олон нийтэд танилцуулав.

Тойм судалгааг бүрэн эхээр нь www.forum.mn вэб сайтаас үзнэ үү.

Ирэх оны төсөвт учирч болзошгүй эрсдэлийг 4 ангилан авч үзэж байгаа ба тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн суваг, гарах үр дагавруудыг мөн тоймлон гаргалаа. Эндээс харахад, гадаад эдийн засгийн таагүй нөхцөл байдал, уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээ, дотоодын эдийн засгийн болон хууль, эрхзүй, бодлогын тогтворгүй байдал зэргээс шалгаалан экспорт, гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) буурснаар дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт саарах, гадаад худалдааны алдагдал нэмэгдэх, валютын ханшийн савалгаа үүсэх зэрэг үр дагаврууд гарахаар байна. Иймд бизнесийн үйл ажиллагааны таатай орчин бүрдүүлэх замаар татварын орлогыг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарах, эдийн засгийг идэвхжүүлэх зорилгоор гаргаж буй бондын эх үүсвэрээр санхүүжүүлэх дэд бүтцийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, ажил эрхлэлт, үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжихийн тулд дотоодын гэрээлэгчдээр гүйцэтгүүлэх зэрэг арга хэмжээ авч болох юм.

Цаашдаа урт хугацаанд Монгол Улсын эдийн засаг гадаадын хөрөнгө оруулалттай нэг салбараас хэт хамаарч байгааг анхаарч энэ хамаарлыг бууруулах, уул уурхайн орлогын удирдлагыг сайжруулах, өөрийн орны харьцангуй давуу тал болох мал аж ахуйн салбарт суурилсан үйлдвэрлэлийг дэмжих, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого баримтлах шаардлагатай байна.

2014 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГОД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

ГОЛЛЛОХ ЭРСДЭЛҮҮД

Гадаад эдийн засгийн таагүй нөхцөл байдал

Уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээнээс үүдэлтэй эрсдэл

Дотоодын эдийн засгийн тогтворгүй байдал

Хууль, эрхзүй, бодлогын шийдвэрийн эрсдэл

ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ СУВАГ

БНХАУ болон бусад томоохон эдийн засгийн эрэлт буурах

Түүхий эд, ялангуяа коксжих нүүрсний экспортын өрсөлдөөн нэмэгдэх

Уул уурхайн салбарын орлогын тасалдал нь валютын ханшийн хүчтэй савлалт үүсгэж эдийн засагт тогтворгүй байдал үүсгэх

Оюу толгойн гэрээний асуудал шийдэгдэхгүй удаж, уурхайн хөрөнгө оруулалт хойшлох, цаашлаад ил уурхайн үйл ажиллагаа тасалдах

ГШХО, уул уурхайн бодлогын орчны тогтворгүй байдал нь сөрөг нөлөөг лавшруулах

ҮР ДАГАВАР НӨЛӨӨЛӨЛ

ДНБ-ий өсөлт хурдтай саарах, худалдааны алдагдал нэмэгдэх

Худалдааны алдагдал төлбөрийн тэнцэлд нөлөөлж, гадаад эдийн засгийн тэнцвэр алдагдах

- Импортын бууралт нь НӨАТ-ын болон гаалийн татварын орлогод сөргөөр нөлөөлөх
- Татварын орлого тасалдаж, төсөвт тодотгол хийх нөхцөл үүсч, төсвийн зорилтууд алдагдах

Гэрээт компаниудын ажил зогсох, олон улсад нэр хүндээ алдах, ЗГ-ын бондын хүү өсөх, нэмэлт хөрөнгө оруулалт зогсох

ГШХО-ын урсгал тасалдан санхүүгийн хүндрэл учирах

Эх сурвалж: ННФ (2013). Монгол Улсын 2014 оны төсвийн төсөлд хийсэн тойм судалгаа

УЛСЫН ТӨСВИЙН АСУУДЛААРХ УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монгол Улсын 2014 оны төсвийн төслийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт зэрэг тойм судалгаагаар гарсан дүгнэлтийг бодлого боловсруулагчид, судлаачид, иргэд болон иргэний нийгмийнхний хүрээнд танилцуулах уулзалт хэлэлцүүлэг өрнүүллээ. 2013 оны 10 дугаар сард “2014 оны улсын төсвийн төслийн орлого төлөвлөлт”, 11 дүгээр сард “2014 оны улсын төсвийн төслийн зарлага, хөрөнгө, өрийн удирдлага” сэдэвт хэлэлцүүлгүүд зохион байгуулагдав.

Уулзалт хэлэлцүүлгийн үеэр Сангийн яамнаас 2014 оны улсын төсвийн төлөвлөлт, Үндэсний аудитын газраас төсвийн төсөлд өгсөн санал, мөн ННФ-ын санаачлагаар судлаачид төсвийн төлөвлөлтөд хөндлөнгийн хараат бус тойм дүгнэлт хийснээ тус тус танилцууллаа. Тойм судалгааны дүгнэлтэд үндэслэн төсвийн орлого төлөвлөлтийг сайжруулах, ирэх онд эдийн засагт үүсч болзошгүй хүндрэлүүдийг төсөвт бодитоор суулгаж, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах, цаашид төсвийн судалгааг онолын үндэслэлтэй хийх, бодлогын уялдааг сайжруулах, бондын хөрөнгийг төсөвт бүртгэх нь зүйтэй гэсэн зөвлөмжийг хараат бус судлаачдын зүгээс гаргасан юм.


2014 оны төсвийн төсөлд хийсэн тойм дүгнэлт, хэлэлцүүлгүүдийн тэмдэглэл, хэлэлцүүлгийн үеэр тавьсан илтгэлүүд болон улсын төсвийн төлөвлөлтийн талаар анхаарах асуудлын талаарх мэдээлэл зэргийг www.forum.mn вэб сайтад нийтэлж, олон нийтэд хүргэлээ. Мөн 2014 оны улсын төсвийн төслийн ил тод байдлыг ажиглаж, төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг олон нийтэд ил тод болгох талаар *My Budget* нийгмийн сүлжээ болон www.forum.mn вэб сайтад асуудал хөндсөн мэдээлэл нийтэлж нөлөөллийн үйл ажиллагаа явуулаад байна.



Зүүн гар талаас: Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга О.Хуягцогт, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, Доктор, профессор, ННФ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Ч.Хашчулуун, Үндэсний аудитын газрын Ерөнхий аудиторын орлогч Б.Батбаяр, ННФ-ын Эдийн засгийн хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам, ННФ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Ж.Үнэнбат, Сангийн яамны Орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Алтанзул
Төсвийн хэлэлцүүлэгт оролцогчид

ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮЛЭЭЛТИЙН ИНДЕКС

ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮЛЭЭЛТИЙН ИНДЕКС 2013




ННФ 2010 оноос эхлэн Санхүүгийн зах зээлийн холбоотой хамтран “Хэрэглэгчийн хүлээлтийн индекс” (ХХИ) судалгааг улирал тутамд хийж байна. ХХИ-ийг тооцож гаргаснаар бизнесийн болон төрийн байгууллага, хэрэглэгчдийн хэрэглээний ирээдүйн хандлагын талаар бодит мэдээлэлтэй болж, үүний үндсэн дээр нийт хэрэглэгчдийн хүлээлттэй уялдсан бодитой шийдвэр гаргах боломжтой болдог. Энэхүү индекс нь ирээдүй рүү хандсан, эдийн засгийн чиг хандлагыг тодорхойлоход, мөн зах зээлийн ирээдүйн төлвийг таамаглахад ашиглагддаг хамгийн чухал индикатор хэмээн эдийн засагч, бизнесменүүд, төрийн албан тушаалтнуудын дунд хүлээн зөвшөөрөгдөөд байгаа юм.

ХХИ-ийг хэрэглэгчдийн хэрэглээний өнөөгийн болон ирээдүйн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор түүвэр судалгаан дээр үндэслэн тооцдог болно. Судалгааг Улаанбаатар хотын 1000 иргэнээс санал асуулга авах замаар гаргаж байна. Түүвэр судалгааны асуултууд нь хэрэглэгчдийн ирээдүйн болон өнөөгийн санхүү эдийн засгийн нөхцөл байдал, үнийн түвшин, ажил эрхлэлт болон банкны салбарын талаарх хүлээлтийг тодорхойлох зорилготой бүлэг асуултуудаас бүрддэг.

ХХИ өмнөх онтой харьцуулахад 2013 оны 1, 2 дугаар улиралд буурсан бол 3 дугаар улиралд сүүлийн гурван жилийн хамгийн доод цэгт хүрч унасан юм. Энэхүү уналтад гадаадын хөрөнгө оруулалтын бууралт, ам.долларын ханшийн өсөлт зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байх талтай. Харин дөрөвдүгээр улиралд ХХИ сэргэж 174 болтлоо өссөн нь судалгааны дүнгээс харагдлаа.

Хэрэглэгчийн хүлээлтийн индекс ба Монголын эдийн засгийн өсөлтийн хамаарал, 2010-2013





Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо. Сарын бюллетень, ХХИ-ийн судалгааны дүн

БИЗНЕСИЙН ОРЧИН

Дэлхийн эдийн засгийн форум (ДЭЗФ) -аас Дэлхийн өрсөлдөх чадварын тайланг жил бүр эрхлэн гаргадаг бөгөөд ННФ уг байгууллагын түншээр 9 дэх жилдээ ажиллаж байна. ННФ тус тайлангийн Бизнесийн байгууллагын удирдах ажилтнуудын судалгааг явуулдаг юм. Өрсөлдөх чадварын энэхүү индекс нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл бөгөөд Монгол Улсын өрсөлдөх чадварыг ижил төстэй улс орнуудтай харьцуулах боломж олгохын зэрэгцээ тухайн улсын өрсөлдөх чадварын талаарх мэдээллийг өгдөг. Мөн зэрэглэлд хамрагдсан улс өрсөлдөх чадварын зэрэглэлээ тодорхойлох, өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг сайжруулах, шинэчлэх боломжийг олгодог юм.

Энэ жилийн Дэлхийн өрсөлдөх чадварын тайланг 9 дүгээр сард дэлхий даяар танилцуулсан бөгөөд ННФ түнш байгууллагын хувьд Монгол Улсын зэрэглэлийг мөн 9 дүгээр сард танилцуулж, судалгааны үр дүнг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж ажиллалаа.

Монгол Улс уг судалгаанд 2005 оноос эхлэн хамрагдсан бөгөөд 2013-2014 онд авбал зохих 7 онооноос 3.7 оноо авч 148 орноос 107-р байрт орлоо. Энэ нь өнгөрсөн онд 144 орноос 93-р байрт орсонтой харьцуулахад ухарсан үзүүлэлт юм. Дэлхийн өрсөлдөх чадварын индекс (ДӨЧИ) нь өрсөлдөх чадварыг тодорхойлох 12 тулгуур үзүүлэлтэд үндэслэдэг бөгөөд энэ удаа 4 үзүүлэлтээр Монгол Улсын оноо буурсан байна. Тухайлбал, макро эдийн засгийн тогтвортой байдал өмнөх тайлангийн үеийнхээс 1.2, бараа бүтээгдэхүүний зах зээлийн үр ашигтай байдал 0.1, хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай байдал 0.2, санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдал 0.1 оноогоор тус тус буурчээ.



Дэлхийн эдийн засгийн форумын Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан, 2013-2014

ДЭЛХИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ДҮНГЭЭС

Монгол Улсын хувьд харьцангуй сайн үзүүлэлтүүд нь эрүүл мэнд, суурь боловсрол (5.6 оноогоор 76-р байр), хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай байдал (4.5 оноогоор 51-р байр), технологийн бэлэн байдал (3.8 оноогоор 66-р байр) юм. Харин

өмнөх жилийнхээс өөрчлөлт гараагүй үзүүлэлтүүд нь институцийн тогтолцоо (3.3 оноо), технологийн бэлэн байдал (3.8 оноо), бизнесийн боловсронгуй байдал (3.3 оноо) болон инноваци (2.9 оноо) байна.

МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН 2013-2014 ОНЫ ИНДЕКС



Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форумын Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2013-2014

2012 оны байдлаар Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 3627 ам. доллар байгаа боловч нийт экспортод эрдэс бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээ өндөр байгаагаас шалтгаалан Суурь хүчин зүйлсэд суурилсан улс орноос Үр нөлөөнд суурилсан үе шат руу шилжиж буй орнуудын ангилалд багтсан хэвээр байна.

Монгол Улсын өрсөлдөх чадварын хувьд анхаарах хамгийн чухал хүчин зүйлс нь институцийн тогтолцоо, дэд бүтэц, макро эдийн засгийн орчин болон санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдлын үзүүлэлт юм. Иймд оюуны өмчийн хамгаалалт, шүүхийн хараат бус байдал, төрийн албан тушаалтан шийдвэр гаргахдаа тал засдаг байдал, төсвийн зарлагын үрэлгэн байдал, дэд бүтцийн чанар, улсын төсвийн алдагдал, инфляци, боловсролын тогтолцооны болон менежментийн сургуулиудын чанар гэх зэрэг олон асуудлуудад анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

Өрсөлдөх чадварын тайланд улс орон бүрийн бизнес эрхлэхэд саад болж буй гол хүчин зүйлсийг тодорхойлон гаргадаг. 2013 оны тайлан судалгаагаар Монгол Улсад бизнес эрхлэхэд саад учруулж буй хамгийн гол сөрөг хүчин зүйлсэд мэргэшсэн ажиллах хүчний дутагдал, төрийн хүнд суртал, дэд бүтцийн хангамж болон санхүүжилт авах боломж хангалтгүй, бодлогын тогтворгүй байдал, авлига хээл хахууль зэрэг үзүүлэлтүүд оржээ.

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахын тулд хувийн секторын үйл ажиллагааг дэмжих бизнесийн таатай орчин бүрдүүлэх нь нэн чухал бөгөөд өрсөлдөх чадварын энэхүү тайлан нь бусад улс орнуудтай харьцуулахад манай улсын өрсөлдөх чадварын давуу ба сул тал болон өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж өгч байгаагаараа ач холбогдолтой юм. ДЭЗФ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу ННФ “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2014-2015”-д орох Монгол Улсын бизнесийн байгууллагуудын удирдах ажилтнуудын дунд явуулах судалгааг хийхээр ажиллаж байна.

УЛС ОРНУУДЫН ХӨГЖЛИЙН АНГИЛАЛ (ДӨЧИ-ээр)

Өрсөлдөх чадварын индексээр нэг хүнд ногдох ДНБ болон нийт экспортод эрдэс бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээнээс хамааран дэлхийн улс орнуудыг Хүчин зүйлсэд суурилсан, Үр нөлөөнд суурилсан, Инновацид суурилсан гэж хөгжлийн гурван үе шатад хуваан авч үздэг.

“Суурь хүчин зүйлсэд суурилсан” ангилалд багтах улс орнууд институцийн тогтолцоо, дэд бүтэц, макро эдийн засгийн тогтвортой байдал, эрүүл мэнд болон суурь боловсролын чиглэлийн шалгуур үзүүлэлтээ сайжруулах шаардлагатай байдаг.

“Үр нөлөөнд суурилсан” орнуудын ангилалд орох үед дээд боловсрол ба мэргэжлийн сургалт, бараа бүтээгдэхүүн, хөдөлмөрийн зах зээл, санхүүгийн зах зээлийн үр ашиг, боловсронгуй байдал, технологийн бэлэн байдал зэрэг хүчин зүйлийг сайжруулахад түлхүү анхаарах хэрэгтэй юм.

“Инновацид суурилсан” хөгжлийн үе шатад байгаа үед (i) бизнесийн боловсронгуй байдал, (ii) инноваци гэсэн хоёр тулгуур хүчин зүйлд түлхүү анхаарах шаардлагатай байдаг.

(i) Бизнесийн боловсронгуй байдалд дотоодын нийлүүлэгчдийн тоо, чанар, бизнесийн бүлэглэлийн хөгжил, үйлдвэрлэлийн үйл явцын боловсронгуй байдал, маркетингийн цар хүрээ, эрх мэдлээ төлөөлүүлэхэд бэлэн байдал зэрэг хүчин зүйл багтана.

(ii) Инноваци гэсэн тулгуур үзүүлэлтэд инноваци гаргах чадвар, шинжлэх ухааны судалгааны байгууллагын чанар, компанийн судалгаа, хөгжилд зарцуулж буй хөрөнгө, их дээд сургууль, аж үйлдвэрийн судалгааны хамтын ажиллагаа, засгийн газрын (дэвшилтэт технологийн бүтээгдэхүүний) худалдан авалт, эрдэмтэд, инженерүүдийн хүрэлцээ зэрэг асуудлууд хамаардаг байна.

Эх сурвалж: Дэлхийн өрсөлдөх чадварын 2013-2014 оны тайлан



БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР

Боловсрол, нийгмийн бодлогын хөтөлбөр нь 2013 онд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгын хүрээнд ажлаа зохион байгуулав. Бодлогын орчинг сайжруулах чиглэлд судалгаа, сургалт, нөлөөллийн ажил хэрэгжүүлэхийн зэрэгцээ энэ салбарт төрөөс үзүүлж буй нийтлэг үйлчилгээ, зорилтот хөтөлбөрүүдийн хүртээмж, үр нөлөөнд хяналт тавьж ажиллах сонирхолтой иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэхэд анхаарч ажиллалаа. Мөн залуучуудын байгуулсан төрийн бус байгууллагын хөгжлийг дэмжих, дүн шинжилгээ, үндэслэл нотолгоотой үзэл бодлоо илэрхийлэх чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлж ирлээ.

НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт 2013 онд чухал өөрчлөлтүүд гарсан. Боловсролын салбарт хүүхэд бүрийг хөгжүүлэх зорилт, нийгмийн халамжийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхэд залуучууд зэрэг нийгмийн бүлэгт тавих анхаарал илүү хүчтэй болж ирлээ. Үүний зэрэгцээ төрийн яам, агентлагууд төлөвлөлт, үнэлгээний ажилдаа иргэний нийгмийн болон судалгаа шинжилгээний байгууллагуудыг идэвхтэй татан оролцуулж байлаа. Энэ нь иргэний нийгмийн байгууллагуудын хувьд хөндлөнгийн үнэлгээ мониторинг, бодлогын зөвлөмжөө төр захиргааны бүхий л шатны албан тушаалтнуудад хүргэх, бодлого шийдвэрт оролцох боломжийг нэмэгдүүлж байна.

ННФ 2013 онд хөгжлийн бэрхшээлтэй болон ядуу иргэдэд хүрч буй төрийн үйлчилгээ, эмнэлгийн үйлчилгээний хүртээмж, орчны бохирдлыг хянах зэрэг асуудлаар мониторингийн төсөл санаачилсан зарим төрийн бус байгууллагад төслөө хэрэгжүүлэхэд нь арга зүйн болон санхүүгийн дэмжлэг

үзүүлж ажиллалаа. Эдгээр байгууллагын хэрэгжүүлсэн мониторингийн төслийг дурдвал:

- Дорнод аймгийн Нийгмийн дэвшил- эмэгтэйчүүд ТББ нэн ядуу өрхийн гишүүдэд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх зорилготой Хүнсний эрхийн бичиг олгох хөтөлбөрт;
- “Гэгээ мандал” ТББ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн урлаг, соёл, спортын оролцоог дэмжихэд чиглэсэн бодлогын хэрэгжилтэд;
- “Дашин дэм” ТББ хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд;
- “Байгаль орчин, эрүүл мэнд” ТББ эрүүл мэндийн салбар дахь мөнгөн усны хэрэглээг багасгах, аажмаар бүрэн татгалзах тухай олон улсын конвенциар хүлээсэн үүргээ Монгол Улс хэрхэн хэрэгжүүлж байгаад тус тус мониторинг хийж эхний дүнгээ гаргаад байна.

Төв аймгийн Ажил олгогч эздийн холбооны санаачилсан “Аймгийн нэгдсэн эмнэлэгт ашиглаж байгаа цахим карт ба эмнэлгийн үйлчилгээний хүртээмж” төсөл, Мэдээлэл шинжилгээ, үнэлгээний төв ТББ-ын “Төрөх эмнэлгийн үйлчилгээ ба авилга” төсөл нь мэдээлэл цуглуулах шатандаа явж байна.

Дорнод аймгийн Нийгмийн дэвшил- эмэгтэйчүүд ТББ нэн ядуу өрхөд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хэрэгжиж эхлээд нэг жил болж байгаа Хүнсний эрхийн бичиг олгох хөтөлбөрт мониторинг хийжээ. Орлогыг орлуулан тооцох арга зүйд суурилан боловсруулсан асуулгаар өрхүүдийн амьжиргааны түвшинг тооцон жагсааж, үндэсний хэмжээнд хамгийн доогуурх 5 хувьд багтсан өрхийн насанд хүрсэн нэг гишүүн бүрт сард 10,000 төгрөг, хүүхэд бүрт 5,000 төгрөгийн хүнсний эрхийн бичиг олгож, гэрээт дэлгүүрээс 10 нэр төрлийн хүнсний бараа олгох дизайнтай энэ хөтөлбөрийн эхний жилд нэлээд өргөдөл, гомдол гарчээ. Судлаад үзэхэд, ихэнх хүндрэл бэрхшээл нь орлого тодорхойлох судалгааны арга зүй, зохион байгуулалттай холбоотой байгаа нь харагдлаа. Дээд боловсролтой ч эрхэлсэн ажилгүй, индүү, телевизор зэрэг гэр ахуйн барааг байнгын хэрэглээ болгоод удаж байгаа, байр орон сууцтай ч эцэг эхээсээ өвлөж аваад, ах дүүсээрээ нийлж нэг дор амьдардаг зэрэг Монголын нийгмийн амьдралын нөхцөл байдлын улмаас дэлхийн бусад оронд хэрэглэсэн орлогыг орлуулан тооцох арга зүй Монголд тохирохгүй байна гэх үндэслэл байна. Мөн өрхүүдээс асуулга авахдаа баг, сумын засаг дарга, нийгмийн ажилтныг оролцуулалгүй оюутнуудыг дайчлан ажиллуулсан нь дээрх албан тушаалтнуудын нөлөөллөөс сэргийлэх зорилготой сайн хэрэг боловч өрхүүд ам бүлийн тоогоо нэмж бичүүлэх, хувиараа эрхэлж буй орлого олох үйл ажиллагаагаа байхгүй мэтээр худал мэдүүлэх, эсвэл асуултаа сайн ойлголгүй буруу хариулах зэрэг алдаа гарахад хүргэсэн байна. Орон гэргүй тэнэмэл, түр оромж юмуу айлын хаяа бараадан амьдардаг хүмүүсийг тодорхой хаяггүй тул өрх гэж тооцох боломжгүй гэсэн ойлголтоор судалгаанд хамруулаагүй байна. Хүнс тэжээлийн дэмжлэг нь ядуу, орлого багатай өрхүүдэд тус нэмэр болж байгаа

тул цаашид үргэлжлүүлэх нь зүйтэй ч арга зүй болон зохион байгуулалтаа сайжруулах, өрхийн аман мэдээллийг баг, сумын албан мэдээлэлтэй тулгаж нягтлах хэрэгтэй байгаа нь энэ мониторингийн үр дүнгээс харагдлаа.

ХҮНСНИЙ ТАЛОНЫ ТУХАЙ

Азийн Хөгжлийн Банкны буцалтгүй тусламж, улсын төсвөөс санхүүжүүлэн хүнс тэжээлийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай амьжиргааны доод төвшинд амьдарч буй өрхийн гишүүдэд хүнсний талон олгох хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Хэн хүнсний талон авах эрхтэй вэ?

Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт зааснаар орлогыг орлуулан тооцох аргаар амьжиргааны түвшинээ үнэлүүлж, мэдээллийн санд орсон иргэдээс хамгийн бага амьжиргаатай буюу батлагдсан босго онооноос доогуур үнэлгээтэй нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд хүнсний эрхийн бичиг олгож байна.

Хүнсний талоноор ямар нэр төрлийн бүтээгдэхүүн авах вэ?

Арван нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг олгоно. Үүнд, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, цөцгийн тос, элсэн чихэр, төмс, хүнсний ногоо, будаа, ургамлын тос, өндөг, жимс, жимсгэнэ орно.

“Гэгээ мандал” ТББ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн урлаг, соёл, спортын оролцоог дэмжихэд чиглэсэн бодлогын хэрэгжилтэд мониторинг хийжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай хуулийн 9.1-д хөгжлийн бэрхшээлтэй иргэн соёл, урлаг, биеийн тамираар хичээллэх боломжийг бүрдүүлээд зогсохгүй үүнд олон улсын болон өөрийн оронд зохиогдож буй арга хэмжээнд оролцоход нь төрөөс дэмжихээр заажээ. 2013 оны хувьд параолимп, дефолимп, мисс, мистерийн тэмцээн, хараагүйчүүдийн наадам зэрэг тодорхой үйл ажиллагаанд төрийн яамд санхүүгийн дэмжлэг үзүүлж дэмжсэний зэрэгцээ нийслэлийн дүүргүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах өдрөөр төрөл бүрийн тэмцээн зохион байгуулсан байна. Эдгээр арга хэмжээ нь тогтмол бус явагдахын зэрэгцээ, цөөн тооны хүн оролцох боломжтой тул хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийтэд нь хамарч чадахгүй байна. Нөгөө талаас, нийтийг хамарсан арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжиж оролцуулахаас илүүтэй зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан шинжтэй байгаа юм. Үүний шалтгаан нь төрийн төв болон орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагаа болон төсвөө зохиож байгаа арга хандлагад оршиж байгаа ба цаашид нийтийг хамарсан урлаг, соёл, спортын үйл ажиллагаа төлөвлөхдөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах,

мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулсан үйл ажиллагааг тогтмолжуулах, өргөжүүлэхэд чиглэсэн төлөвлөлт, төсвийн хуваарилалт хийх хэрэгтэй байгааг мониторингийн тайланд онцолжээ.



Зурагт зүүн гар талаас: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын арга хэмжээнд оролцогчид; 29-р тусгай сургуулийн уран зургийн багш Ш.Дашдэндэв шавь нарын хамт, Хүүхдүүдийн зарим бүтээл 2013 он.

“Дашин дэм” ТББ хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд мониторинг хийв. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хэмжээг тогтоож, халамжийн тэтгэвэр авах эрхийг нээж өгдөг энэ Комиссын гишүүд өөрсдийгөө маш өндөр ачаалал, хахууль авсан байх гэсэн байнгын хардлага, буруу дүгнэлт гаргасан гэх тогтмол шүүмжлэл дунд журмын дагуу ажиллаж байгаа гэж үзэж байхад иргэдээс эмч нарын зан ааш муу тул айдастай, бие биенээ үгүйсгэсэн зүйл хэлдэг тул итгэл төрдөггүй, хахууль авсан байх гэж сэрддэг, чирэгдэл ихтэй, нөхөн сэргээх болон хөдөлмөр эрхлэлтэд зуучлах үүргээ огт биелүүлдэггүй гэсэн шүүмжлэл гарч байна. Хурлын зохион байгуулалттай холбоотойгоор эмч, үйлчлүүлэгчид Комиссын нэг удаагийн хурлаар орох хүний тоо их, хүлээх байрны багтаамж, агааржуулалт, эрүүл ахуй болон ариун цэврийн нөхцлийг сайжруулах хэрэгтэй гэсэн ижил санал гаргажээ. Түүнчлэн хурлын үйл явц, гарсан шийдвэрийн үндэслэлийг мэдээлж байхыг үйлчлүүлэгчид хүсэж байна. Өнөөгийн энэхүү үл ойлголцол, харилцан хүндэтгэлгүй байдлыг арилгаж эмч, үйлчлүүлэгчдийн хамтын ажиллагаанд түшиглэсэн үйлчилгээ болохын тулд хөгжлийн бэрхшээл болон хөдөлмөрийн чадвар алдалтыг ялгаж салгасан тодорхойлолттой болж, Комиссоос баримтлах үнэлгээний суурь болгохын зэрэгцээ Комиссын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох хэрэгтэй гэж “Дашин дэм” ТББ зөвлөж байна.

Байгаль орчин, эрүүл мэнд ТББ мөнгөн усны хэрэглээг багасгах, аажмаар бүрэн татгалзах тухай олон улсын конвенциар хүлээсэн үүргээ Монгол Улс хэрхэн хэрэгжүүлж байгааг эрүүл мэндийн салбарын хүрээнд авч үзжээ. Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд мөнгөн ус агуулсан багаж, хэрэгслүүдээс татгалзаж, шүдний эмнэлгүүд мөнгөн устай ломбо ашиглахаа больж, мөнгөн усгүй дижитал багаж, хэрэгсэл, технологи ашиглаж байна. Гэтэл эмийн сан, бөөний худалдааны төвүүд мөнгөн устай халууны шил зэргийг хувь хүнээс бөөнөөр худалдан авч, иргэдэд худалдаалж байгаа бөгөөд үнэ хямд, хэрэглэж сурсан зэрэг шалтгаанаар иргэд дижитал халууны шилнээс илүүтэй авдаг байна. Дараагийн нэг асуудал бол мөнгөн ус асгарсан тохиолдолд аюулгүйгээр авч хадгалах, бохирдсон орчныг хоргүйжүүлэхэд бэлэн байх явдал юм. Мөнгөн ус асгарвал дагаж мөрдөх процедур батлагдсан нь тун сайн хэрэг боловч хэрэгжиж чадахааргүй байна. Мөнгөн ус асгарвал Онцгой байдлын ерөнхий газраас орчныг хоргүйжүүлэх бэлтгэл хангагдсан ч асгарсан бодисыг хадгалах сав байхгүй учраас 2010 онд хагарсан даралт хэмжигчийн мөнгөн усыг 3 дугаар нэгдсэн эмнэлэг өөрийн хог хаягдлын байранд хадгалсаар байгаа ажээ. Мөн ахуйн орчинд хэрэглэж байгаа мөнгөн устай багаж, хэрэгсэл нь хагарвал иргэд тоос сорогчоор соруулах, жорлондоо хийж ус татах, хогийн савандаа хийх зэргээр өөртөө болон орчиндоо нэн хор хөнөөлтэй аргаар зайлуулж байна. Цаашид мөнгөн усны хэрэглээг багасгахын тулд ахуйн орчинд хэрэглэх мөнгөн устай багаж, хэрэгслийн нийлүүлэлтийг зогсоож, хэрэглээнд байгааг нь дижитал багаж хэрэгслээр солих, эмнэлэг, Онцгой байдлын ерөнхий газрын бэлтгэл, бэлэн байдлыг хангуулахад анхаарах хэрэгтэй байгааг мониторингийн зөвлөмжид онцолжээ.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА

Хөгжлийн бэрхшээлийн талаарх эмнэлгийн загвар:

Энэ загвар нь хөгжлийн бэрхшээлийг өвчин, гэмтэл, эмгэгээс шалтгаалсан хувь хүний эрүүл мэндийн доройтол гэж үзэн, үүнийг шийдэхэд зөв оношилж эм, эмийн хэрэгслийг зөв сонгож чадах эмч хамгийн чухал үүрэгтэй гэж үздэг.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх нийгмийн загвар:

Энэ хандлага нь хөгжлийн бэрхшээл бол нийгмийн өөрийнх нь бий болгосон ойлголт бөгөөд тодорхой нэг хувь хүний шинж чанар биш, харин багагүй хэсгийг нь нийгэм өөрөө бий болгосон ээдрээтэй нөхцөл байдал гэж үздэг. Тиймээс хөгжлийн бэрхшээлийн асуудалд нийгмийн эв санаа, хамтын хариуцлагын байр сууринаас хандаж, нийгмийн амьдралаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саад тотгор болохооргүйгээр зохион байгуулах нь чухал юм.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх өглөг хандивын загвар:

Энэ хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг азгүй нөхцөл байдлын золиос гэж харах ба өрөвдөнгүй хандах, өглөг тэтгэлгээр дэмжих хэрэгтэй гэж үздэг. Энэ загвар нь эмнэлгийн загвартай нийлээд хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсийн дунд хамгийн өргөн тархсан ойлголт юм.

Хөгжлийн бэрхшээлд хандах хүний эрхийн хандлага:

Хүний эрхэд суурилсан хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх эдлэгч гэж үздэг нь төр засагт эрхээ хангуулах идэвхтэй шаардлага тавих суурь болно. Хүний эрхийн хандлагаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч байгаа “асуудал”, “саад” нь “зөрчил” болох тул арилгах, сайжруулах шаардлага тавих үндэслэл болно.

БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

ННФ 2004 оноос чанартай боловсролын үйлчилгээнд хүүхэд бүрийг хамруулах бодлогын асуудалд тууштай анхаарч ирсэн билээ. Манай улс суурь боловсролын хамрагдалтаараа бүс нутаг, бүр дэлхийн хэмжээнд чамлахааргүй түвшинд хүрсэн гэдэг ч ерөнхий боловсролын сургуулийн ердийн хөтөлбөрийн дагуу чанартай сайн сургалтад хамрагдаж, үе тэнгийнхэнтэйгээ мөр зэрэгцэн суралцах эрх нь хангагдаагүй хүүхдүүд байсаар байна. ННФ нь бусад төрийн бус байгууллага, судлаачидтай хамтран чанартай сайн боловсрол эзэмшиж чадахгүй хоцрох эрсдэлтэй хүүхдүүдийн нөхцөл байдлын талаар баримт мэдээлэл бүрдүүлэн бодлого боловсруулагчдад хүргэх, төрөөс авч хэрэгжүүлэх арга хэмжээ, бодлогын хувилбаруудыг санал болгон ажиллаж байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЖ БҮЙ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Чанартай сайн суурь боловсрол эзэмшиж чадахгүй үлдэж буй хамгийн том нийгмийн бүлэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тусгай сургуульд сургах хандлага манай улсад 1960-аад онд анх хэвшсэн нь одоо болтол хэвээр байгаа бөгөөд 2013 онд ННФ тусгай сургуулиудын үйлчилгээнд мониторинг хийх ажлыг зохион байгууллаа. Тусгай сургуулиудын мониторингийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн холбоо ТББ гүйцэтгэсэн бөгөөд ННФ-аас арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, цаашид нөлөөллийн ажлыг хамтран гүйцэтгэх юм.

1990 онд Монгол Улс Бүх нийтийн боловсролын төлөө олон улсын санаачилгад нэгдэн орсноор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгмийн амьдрал, боловсролын үйлчилгээнд бусад хүүхдээс тусгаарлалгүй тэгш хамруулах үүрэг амлалт авсан боловч тусгай сургуульд ялгаварлан сургах бодлого хэрэгжүүлсэн хэвээр байна. Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлд “Ерөнхий боловсролын тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, бие даалгах үйлчилгээ үзүүлж, бага, суурь, бүрэн дунд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн” гэж зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бусад хүүхдээс тусгаарлан тусгай сургуулийн орчинд сургах эрх зүйн орчин хадгалагджээ. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт 6 тусгай сургууль бүгд Улаанбаатар хотод байгаагийн дээр сонсголын бэрхшээл (29 дугаар сургууль), харааны бэрхшээл (116 дугаар сургууль), оюуны бэрхшээл (25, 55, 70, 63 дугаар сургуулиуд) гэх мэтээр хөгжлийн бэрхшээлээрээ төрөлжсөн шинжтэй байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд зөвхөн өөртэй нь ижил хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй л харилцах боломжийг


олгож, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь лавшруулан тусгаарлаж байгаа мэт харагдаж байна. Улмаар сургуулиа төгсөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн амьдралд дасан зохицох, бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүмүүстэй хамтран ажиллахад суралцах зэргээр дахин нийгэмших шаардлагатай болдог байна.

Улсын хэмжээнд байгаа 6 тусгай сургуульд нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 5 хүрэхгүй хувь нь сурч байгаагийн дээр хөдөө орон нутагт тусгай сургууль байхгүй зэрэг нь тусгай хэрэгцээт боловсролын хүртээмж тун хязгаарлагдмал байгаагийн тодорхой илрэл юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн ерөнхий боловсролын сургуулийн анги танхимд сургах туршлага манай улсад ч мөн дэлгэрч байгаагийн ачаар 10.0 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн сургуульд сурч байгаа тухай БШУЯ мэдээлсэн байна (2012-2013 оны боловсролын салбарын статистик мэдээ). Харамсалтай нь, VSO олон улсын байгууллага, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдийн холбоо, 2010 оны Хүн ам орон сууцны тооллогын мэдээ зэрэг эх сурвалжуудын дүнтэй дээрх албан статистик нэлээд зөрүүтэй байгаа юм. Сургалтын орчны хувьд ердийн ерөнхий боловсролын сургуулийн багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн, мэргэжилтний зөвлөгөө дэмжлэгээр хангагдаж чаддаггүй ажээ.

Тусгай сургуулиуд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх үндсэн газар болохын хувьд ердийн сургуультай харьцуулбал сургалтын орчин, мэргэшсэн боловсон хүчнээр илүү хангагдсан байх ёстой. Гэтэл мониторингийн дүнгээс харахад тусгай хэрэгцээт боловсролын сурах бичиг улсын хэмжээнд нэн ховор тул тохиромжгүй ч гэсэн энгийн сургуульд зориулсан сурах бичиг хэрэглэх, тараах материал байхгүй тул багш нар өөрсдөө хийх зэргээр аргалж ирсний нэг шалтгаан нь тусгай хэрэгцээт боловсролын төсвийг олон жилийн турш дутуу төлөвлөж ирсэн явдал гэж үзэж байна. Багш нарын ихэнх нь цалин хүрэлцэхгүйн улмаас банкнаас зээл авсан хэрнээ цалингаасаа сургалтын хэрэглэгдэхүүн худалдаж авдаг тухай ярьжээ. Сургууль нь мөн дадлагын хичээлд хэрэглэх материалыг зээлээр авч, цалингийн төсөв, сургуулийн урсгал болон тогтмол зардлын өртэй гарсан байна.

Боловсон хүчний хувьд согог зүйчид 1990 оноос өмнө хуучин Зөвлөлт Холбоот Улсад бэлтгэгдсэн мэргэжилтнүүд байгаа ба тусгай хэрэгцээт боловсролын багш гэсэн мэргэжил байхгүй байна. Мэргэжлээ дээшлүүлэхийн тулд багш нар зээл авч кредиттэй сургалтад хамрагддаг ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад нэмэр болох агуулга, арга зүйн мэдлэг нэмж авч чаддаггүй, ур чадварын уралдаан боллоо гэхэд энгийн сургуулийн нэг ангид очиж хичээл заадаг байна. Улмаар тусгай хэрэгцээт боловсролын багш, засалчид Монгол Улсад бэлтгэгдэхгүй, ийм мэргэжлийн чиглэл ч алга байгааг анхааралдаа авч, даруйхан бодлогын арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Энэхүү мониторингийн дүнгээс харахад манай улс богино хугацаандаа тусгай сургуулиудыг мэргэжил, арга зүйн дэмжлэг, сургах орчныг сайжруулахад анхаарахтай зэрэгцүүлэн дунд хугацаандаа ерөнхий боловсролын ердийн анги танхимд тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг хүргэх эрх зүйн орчин, боловсон хүчний болон арга зүйн бэлэн байдлаа хангаж ажиллах хэрэгтэй байгаа нь харагдлаа.



Т.О.С. БАРИМТ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд

Төгсөлтөг

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын ажиллах орчин, боловсролын үйлчилгээний талаарх тоо баримтыг багцлан ННФ-аас “Тоо баримт” цуврал болон инфографик гаргаад байна. Эдгээр бүтээгдэхүүн нь тухайн асуудлаар ажилладаг бодлого боловсруулагчид, судлаачид, эцэг эхийн холбоод болон иргэний нийгмийнхэнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай гол статистик мэдээллийг харахад тус болохуйц эх сурвалж боллоо. Эдгээр бүтээгдэхүүнийг www.forum.mn сайтаас бүрэн эхээр нь үзнэ үү.

Т.О.С. БАРИМТ, ИНФОГРАФИК


Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо баримтыг багцлан ННФ-аас “Тоо баримт” цуврал болон инфографик гаргаад байна. Эдгээр бүтээгдэхүүн нь тухайн асуудлаар ажилладаг бодлого боловсруулагчид, судлаачид, эцэг эхийн холбоод болон иргэний нийгмийнхэнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай гол статистик мэдээллийг харахад тус болохуйц эх сурвалж боллоо. Эдгээр бүтээгдэхүүнийг www.forum.mn сайтаас бүрэн эхээр нь үзнэ үү.

ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ ИНДЕКС

Боловсролд тэгш хамруулах зарчим нь хүүхэд бүр өөрийн өвөрмөц хэрэгцээтэй бөгөөд сургууль хүүхэд бүрийн хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн хөгжүүлэх, сургах үйлчилгээ үзүүлэх газар гэсэн хандлага, философид суурилдаг. Энэхүү тэгш хамруулах боловсролын зарчим нь дэлхийн олон улс орны боловсролын бодлогын суурь болж ирсэн бөгөөд тэдний хуримтлуулсан туршлага бидэнд мэдлэг, мэдээллийн эх сурвалж болох юм.

Их Британийн Норфолк муж боловсролын тогтолцоогоо тэгш хамруулах үнэт зүйлсэд суурилан оролцоотойгоор хөгжүүлэх туршилтыг боловсролын судлаачидтай хамтран хэрэгжүүлж байна. Тэдний ашиглаж байгаа арга зүйг Тэгш хамрагдалтын индексийн сүлжээ хэмээх боловсролын судалгаа, сургалтын байгууллага анх боловсруулж, одоо 40 гаруй улсад хэрэглэж байна. Энэ нь сургууль өөрийн үнэлгээ хийж, илүү нээлттэй, тэгш хамруулах орчин болохын тулд хийх ажлаа төлөвлөн, Сургууль хөгжүүлэх төлөвлөгөөндөө тусгах замаар үйл ажиллагааны өөрчлөлт шинэчлэл хийхэд чиглэсэн арга зүй юм.

Энэхүү арга зүйг тодорхой танилцуулж, хэрэгжүүлэх алхмуудыг нэгбүрчлэн тайлбарласан “Тэгш хамрагдалтын индекс” номын 3 дахь удаагийн сайжруулан, дэлгэрүүлсэн хувилбарыг монгол хэлнээ орчуулж, сургуулиудад хүргэх ажлыг ННФ санаачлан санхүүжүүлж, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг (БХАН) төрийн бус байгууллага гэрээгээр гүйцэтгэж байна. Сургалтын шинэлэг арга зүйг багш нарт эзэмшүүлэх чиглэлээр 2003 оноос хойш амжилттай ажиллаж байгаа энэ байгууллага өөрийн өргөн хүрээт гадаад харилцаа, хамтын ажиллагааны сүлжээгээрээ дамжуулан сургагч багш, нэмэлт санхүүжилт дайчлан ажиллах юм. ННФ болон БХАН-ийн хамтарсан энэ төсөл 2014 онд үргэлжлэх юм.



ННФ-ын Боловсрол, Нийгмийн хөтөлбөрийн менежер А.Гэрэлмаа
“Дэлхий нийтээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг энгийн сургуульд бусад хүүхдүүдтэй хамт сургах хандлагыг 1970-аад оноос хэрэгжүүлээд эхэлчихсэн.”



С. Сэлэнгэ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эхийн холбооны Гүйцэтгэх захирал
“Боловсролд тэгш хамруулах зарчмаар хүүхдүүдийг анхнаасаа хамтад нь сургалтын нэг орчинд байлгахад ялгаварлан гадуурхах, үл ойлгох явдал аажимдаа арилдаг юм байна.”



Р. Будханд, БЗД-ийн 147-р цэцэрлэгийн эрхлэгч
“Багш хүүхдийг байгаагаар нь хүлээн зөвшөөрч үйлчилгээ үзүүлэх сэтгэл байхад, энэ сэтгэл зүтгэлийн үр дүн гарна.”



БХАН-ийн Боловсролд тэгш хамруулах хөтөлбөрийн менежер О.Саранцэцэг
“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусдаас тусгаарлагдахгүй, бусад хүүхдүүдтэй хамт суралцах нь тэр хүүхдэд хөгжих маш их боломж олгодог.”



Д.Тунгалаг
“Бүх нийтийн боловсролын төлөө” иргэний нийгмийн үндэсний эвслийн зохицуулагч
“Тусгай сургууль байгуулж тусгайлан сургаснаас боловсролд тэгш хамруулан сургах нь бараг 9 дахин хямд зардал гардаг” гэсэн эдийн засагчдын тооцоо бий.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

ННФ нь 2013 оноос Нээлттэй Нийгэм Сангуудын Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөр, Боловсролыг дэмжих хөтөлбөртэй хамтран Монгол Улсад бага насны хөгжлийн хоцрогдолтой, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нэмэлт үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бий болгох зорилготой 3 жилийн төсөл хэрэгжүүлж эхлээд байна. Энэ төслийн хүрээнд юуны өмнө бусад улс орон бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нэмэлт үйлчилгээ, үүнтэй нягт холбоотой тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээгээ хэрхэн зохион байгуулж, санхүүжүүлэн ажиллаж байгаатай танилцах зорилгоор туршлага судлах аялал зохион байгуулж, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын төрийн захиргааны болон үйлчилгээ хүргэгч байгууллагуудын төлөөлөгчдийг хамруулах юм. Энэхүү аяллын бэлтгэл ажил 2013 онд бүрэн хангагдсан ба 2014 оны 2 дугаар сард хийгдэхээр төлөвлөгдөж байна.

Энэхүү танилцах аяллыг зохион байгуулах АНУ-ын Миннесота мужийн Их сургуулийн судлаачдын баг 2013 оны 10 дугаар сард манай улсад ирж, бодлого боловсруулагчид болон үйлчилгээний байгууллагуудын ажилтнуудтай уулзаж ярилцан, үйл ажиллагаа болон эрх зүйн орчныг судалсан юм. Мөн 2013 оны 12 дугаар сард Нээлттэй Нийгэм Сангуудын Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн менежер Холли Хикс-Смолл Монголд ирж ажиллан, бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, саатлыг илрүүлэх, хүүхдийн хөгжлийн хэрэгцээг нарийвчлан үнэлэх чиглэлээр дотоодын болон олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай танилцахын зэрэгцээ бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нэмэлт үйлчилгээний талаарх нэг өдрийн сургалт хийж, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдөд мэдээлэл хүргэлээ.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛД ХӨНДЛӨНГӨӨС ОРОЛЦОХ

EARLY CHILDHOOD INTERVENTION

Хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хөгжлийн хоцрогдлыг аль болох эрт илрүүлэн, дэмжин хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж чадах юм бол хөгжлийн бэрхшээлтэй болох магадлалтай байсан хүүхдүүдийн 30 хувь нь хэвийн хөгжлөө гүйцдэг ажээ. Үлдсэн 70 хувь нь хэрэгцээндээ нийцсэн үйлчилгээг авч бусадтай хамт сурч, бага хэмжээгээр бие даан амьдрах боломжтой болдог байна. Хүүхдийн амьдралын эхний 3 жилд тархины шинэ холбоосууд хамгийн эрчимтэйгээр үүсэж бие, сэтгэл, харилцааны хамгийн хурдацтай хөгжил явагддаг учраас 0-3 настай хүүхдийг анхаарч, хөгжил нь хэвийн явагдаж байгаа эсэхэд ажиглалт хийж, ямар нэг хоцрогдрол, саатал илрэх юм бол хөгжүүлэх нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай байдаг ажээ. Хүүхдийг төрөхөөс нь эхлээд ажиглан, хөгжлийн стандартаа гүйцэж байгаа эсэхэд нь хяналт тавьж хоцрогдол, саатал илэрсэн тохиолдолд мэргэжлийн үнэлгээ хийж үйлчилгээ үзүүлдэг тогтолцоог бага насны хүүхдийн хөгжилд хөндлөнгөөс оролцох, интервенц хийх (*Early Childhood Intervention*) гэж нэрлэдэг ажээ.

Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр 2013 онд манай улсын төрийн бодлогод маш тодорхой ахиц гарсан нь хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлж, шаардлагатай үйлчилгээнд зуучилж, үйлчилгээний хүргэлтэд хяналт тавьж ажиллах тогтолцооны суурь тавигдсан явдал юм. Өмнө нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс 16 нас хүрсэн хойноо л Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор орж, хөгжлийн бэрхшээл буюу хөдөлмөр алдалтын хувь хэмжээгээ тогтоолгон, халамжийн тэтгэвэр авах эрхээ нээлгэдэг байсан бөгөөд хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох, нэмэлт үйлчилгээ хэрэгтэй болохыг нь тогтоож, зуучлан хамруулах механизм байгаагүй юм. Хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын комисс нь төв комисс болон аймаг, дүүргийн салбар комиссуудаас бүрдэх ба энэ тогтолцоо нь хөгжлийн хоцрогдолтой болон хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдүүдийг илрүүлэх, хэрэгцээг нь үнэлэх, шаардлагатай үйлчилгээнд зуучлах ажлыг удирдан хэрэгжүүлэх юм.

2014 онд ННФ энэ чиглэлийн үйл ажиллагаагаа улам эрчимжүүлж, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамд, иргэний нийгмийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нэмэлт үйлчилгээний эрх зүйн орчинг юуны өмнө бий болгох чиглэлээр ажиллах юм. Туршлага судлах ажлын зэрэгцээ Монгол Улсад сургалтууд зохион байгуулах, гарын авлага, удирдамж заавар боловсруулах, эрх зүйн болон арга зүй баримт бичгүүдийг боловсруулж турших, ингэхдээ манай улсад ажиллаж буй олон улсын байгууллага, дотоодын иргэний нийгмийн байгууллагуудтай нягт хамтран ажиллахаар төлөвлөөд байна.



Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нэмэлт үйлчилгээний талаарх нэг өдрийн сургалт, 2013 оны 12 дугаар сар.

Зүүн гар талд: Сургалтад оролцогчид

Баруун гар талд: Нээлттэй Нийгэм Сангуудын Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн менежер Холли Хикс-Смолл



Манайд улсад хүүхдийн хөгжлийг хянах ажлыг өрхийн эмнэлгүүд хийж ирлээ. Хөгжлийн хоцрогдол, саатал илэрвэл хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх биш, харин өвчний оношийг тогтоох, эмчилгээ хийх эмнэлгийн загвар, хандлага давамгайлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний гэр бүлд нийгмийн халамжийн мөнгөнөөс өөр ямар нэг үйлчилгээ, дэмжлэг байхгүй байгааг ННФ-ын дэмжлэгтэйгээр нугасны эвэрхийтэй хүүхдүүдийн “Марал элч сан”- ийн 2013 онд хийсэн мониторингийн дүн харуулж байна. Нугасны эвэрхий бол нүдэнд илт харагдах төрөлхийн гаж хөгжил бөгөөд бусад оронд хүүхдийн эмнэлгүүд нь хүүхэд


төрснөөс хойшхи 72 цагийн дотор нугасны эвэрхийд оёдол тавьж, мэс заслын аргаар засан сэргээдэг байна. Үүний үр дүнд хүүхдийн цаашдын хөгжил хэвийн явагдах ба бие, оюуны ямар нэг бэрхшээл үүсдэггүй байна. Харин Монгол Улсад нугасны эвэрхийтэй хүүхэд төрөхөд эх нь зөвшөөрвөл эвтанази хийх санал тавьдаг, зөвхөн 3 дугаар төв эмнэлэгт оёдол тавих журамтай тул шилжүүлэх гэж цаг алддаг, ямар нэг арга хэмжээ авалгүй байсаар төрөхөөс гарч түүнээс хойш ямар ч эмчилгээ, үйлчилгээ үзүүлдэггүй. Зөвхөн эцэг эх нь хөөцөлдөж байж гадаадад оёдол тавиулдаг ч цаг алдсан тул хөдөлгөөний, оюуны зэрэг хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй болчихсон байдаг.

ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

Өмнөх жилийн Залуучуудын оролцоог дэмжих хөтөлбөрийн үргэлжлэл болгож 2013 онд залуучуудын үүсгэл санаачлагаар байгуулагдсан “Хүүхэд хүүхдийн төлөө” ТББ-ыг чадавхжуулах чиглэлээр хамтран ажиллалаа. Энэ нь тодорхой нэг төслийн хүрээнд бус байгууллагын хөгжлийг дэмжих тэтгэлэг болсноороо онцлогтой байв.

Төслийн хүрээнд “Хүүхэд хүүхдийн төлөө” байгууллага судалгаа, шинжилгээ, мэдээлэл боловсруулах чиглэлээр байгууллагынхаа чадавх, хөгжүүлэх хэрэгтэй байгаа ур чадвараа тодорхойлсны үндсэн дээр эн тэргүүний хэрэгцээгээ бодлогын асуудлаар бичих, бусад залуучуудыг манлайлахад суралцах гэж тодорхойлсон болно. Улмаар 2013 оны туршид энэ ТББ-ын залуучууд сэтгүүл зүй, фото зургийн болон ярилцлага авах, бичих зэрэг судалгааны арга зүйн сургалтуудад хамрагдан, багаараа болон бие даан ярилцлага авч, нийтлэл бичиж, өөрийн вэб хуудсаар дамжуулан олны хүртээл болгож ирлээ. Манлайллын туршлага, дадлагатай болох зорилгоор гэр болон орон сууцны хоёр хороон дээр Залуучуудын зөвлөл байгуулж, хороонд тулгараад байгаа хүндрэлтэй асуудал, шийдэх арга замыг хэлэлцэх жижиг төсөл хэрэгжүүлээ.

Мөн энэ төслийн хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн оюутнуудын судалгааны төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлж ажилласан нь их дээд сургуулийн оюутнуудыг эмпирик судалгааны сонирхол, туршлагатай болгох зорилттой байлаа. Нийслэлийн орон сууцанд амьдарч байгаа өрхүүдийг цахилгаан, усаа хэмнэлттэй хэрэглэхэд сэдэлжүүлэх зорилготой энэ төслийн хүрээнд өрхийн цахилгаан, усны сарын төлбөрийн нэхэмжлэлийг оновчтой хэлбэр форматаар хүргэж байх юм бол ус, цахилгааны хэрэглээ 10 хүртэлх хувиар буурч болохыг энэ төсөл харуулсан юм. Төсөлд хамрагдсан 1200 өрх тус бүрт 6 сарын туршид тухайн өрхийн тухайн сарын цахилгаан, усны төлбөрийн дүн, тухайн байрны дундаж төлбөрийн хэмжээтэй харьцуулсан графикийн хамт хэвлэн хүргэж, заримдаа ус, цахилгаанаа хэрхэн хэмнэх тухай товч мэдээлэл хүргэсний эцэст ийм үр дүн ажиглагдсан болно. Төсөл хэрэгжүүлсэн ЭМШУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн баг Цахим Өртөө коллежийн зохион байгуулсан оюутны эрдэм шинжилгээний хуралд энэ судалгаагаа танилцуулан, өргөмжлөл хүртсэн юм.



ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ, ПОРТАЛ САЙТ

НЭЭЛТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАХ



WWW.FORUM.MN



HTTPS://TWITTER.COM/
FORUMOS



WWW.FACEBOOK.COM/
OPENSOCIETYFORUM




WWW.YOUTUBE.COM/
USER/OSFMONGOLIA

ННФ-ын мэдлэг мэдээлэл түгээх гол хэрэгсэл болох Хөгжлийн Мэдээллийн төв, Портал сайтын (www.forum.mn) үйл ажиллагаа нь 2013 онд үндсэндээ нэгдмэл хэлбэрт орж онлайнаар мэдээллээ түгээхээс гадна олон нийтийн сүлжээг түлхүү ашиглах бодлого баримталж, электрон агуулгын хүртээмж, чанарт анхааран мэдээллийг аль болох олон хувилбараар олон нийтэд хүргэхээр зорьж ажиллалаа.

Портал сайтаараа дамжуулан Монголын хөгжлийн асуудлаарх шинэ судалгаа, үнэлгээ, тоо баримт зэргийг олон нийтэд хүргэсний зэрэгцээ эдгээр мэдээллээ олон нийтийн сүлжээ (Twitter, Facebook хуудас)-гээр тогтмол цацаж байсан нь тодорхой хэмжээгээр нийтийн анхааралд өртөж нийтдээ 5000 гаруй хэрэглэгч үзэж ашиглан, шэйрилж, лайк даржээ. Тухайлбал, “Хөнгөвчлөх үйлчилгээ ба Хүний эрх” сэдэвт олон нийтэд зориулсан лекцийн зарлалыг нэг өдрийн дотор 3602 хүн үзсэн нь энэ оны дээд үзүүлэлт болов. Түүнчлэн, байнга нэмэгдэж байдаг судалгааны санд одоогоор Монголын нийгэм, эдийн засгийн холбогдолтой 1000 гаруй судалгааны тайлан, үнэлгээ байгаа ба уг сан руу 2013 онд нийт 162 600 гаруй хэрэглэгч хандсанаас 51 043 нь ямар нэг судалгаа мэдээлэл татаж ашиглажээ.

Мэдээлэл солилцох, хүлээн авах хүрээнд гадаадын хэвлэн нийтлэлчдийн зарим номыг захиалан авч мэдээллийн сангаа баяжууллаа. ННФ-аас шинээр гаргасан ном, судалгаа орон нутгийн нийтийн номын санд мөн хүргэгдлээ. Түүнчлэн, энэ онд Мэдээллийн төвийн үйлчлүүлэгчид зөвхөн Монголын хөгжлийн сэдвээрх судалгааны тайлан үнэлгээ төдийгүй дэлхийн олон оронд хүртээмжтэй Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD), Кэмбриджийн сэтгүүлүүд, Оксфордын лавлах ном болон толь бичгүүд, Азийн Хөгжлийн Банк, Олон Улсын Валютын сан болон Дэлхийн Банкны и-номын сангуудыг онцгой эрхээр ашиглаж байв.

ННФ-ын эрхлэн гаргадаг “Бодлогын асуудал”, “Хуулийн шүүмж”, “Монитор”, “Тоо баримт”, инфографик зэрэг цуврал бүтээгдэхүүн болон үйл ажиллагааны тодорхой сэдвүүдээр гарах богино видео бичлэгийн онлайн сан нь 2014 онд тогтмол шинэчлэгдэн ашиглалт нь нэмэгдэх хандлагатай байна.



БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

2013 онд Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн дизайныг өөрчлөн, модуль сургалтын хэлбэрт оруулан хэрэгжүүлж эхлээд байна. Өдөр тутмын ажлаасаа чөлөө авч, судалгаанд бүрэн төвлөрөх боломж муутай иргэний нийгмийнхний хэрэгцээнд илүүтэй нийцүүлэх үүднээс энэхүү өөрчлөлтийг хийсэн юм. Улмаар өмнө нь 6 сарын тэтгэлэгт хөтөлбөрийн эх, дунд, төгсгөлд тус бүр гурав хоногийн сургалтуудаар бодлогын судалгааны арга зүй, тайлан бичих, нөлөөллийн стратеги боловсруулах тухай агуулгыг хүргэдэг байсан бол энэ жилээс долоо хоног бүр хоёр цагийн семинараар хоёр сарын туршид арга зүйн мэдлэг олгох, цаашдаа сард хоёр удаагийн семинараар бусад агуулгыг судлах загвараар хөтөлбөрийн сургалтын хэсгийг зохион байгуулж байна.

2013 оны бодлогын судалгааны тэтгэлэгт шалгарсан төслүүд

Нэр, албан газар	Сэдэв
Ч.Алтангэрэл, ХЭҮК	ЕБС-ийн үйл ажиллагаанд хүний эрхийн аудитын арга зүйг нэвтрүүлэх
Ц.Эрдэнэчимэг, Ч.Гэрэлмаа, Нийгмийн ажлын хөгжлийн төв ТББ	Сургуулиас ажлын байр руу шилжих шилжилтийг дэмжих бодлого, хөтөлбөр
С.Дуламсүрэн, Ц.Бүжин, Н.Нарангэрэл, Шинэ нийгмийн эрүүл мэнд ТББ	Эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмж худалдаж авахад баримтлах үр ашиг, хэрэгцээний үнэлгээний механизм боловсруулах
Ж. Алтайбаатар, Үндэсний хөгжлийн хүрээлэн	Нийтийн эрх ашгийг хамгаалах зорилготой иргэний нийгмийн байгууллага ба мэргэжлийн холбоодын чиг үүрэг
М.Алтанбагана, Үндэсний хөгжлийн хүрээлэн	Бодлого, хөтөлбөрийн босоо уялдаа холбоо: Байгаль орчны бодлогын кейс дээр
Д.Цэрэнжав, Ил тод байдал сан	Төрийн байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүд
М.Ариунтунгалаг, Төсвийн сүлжээ	Худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал
Н.Гэрэлмаа, Транспаренси интерншл	Авилгаас сэргийлэх стратеги
Б. Золзаяа ц А. Аударь Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд	Жендерийн тэгш байдал
С.Билгүүн, Ц.Болортуяа, Шүүхийн ерөнхий зөвлөл	Хуулийн шүүмжийг хэвшүүлэн хууль боловсруулалтын чанарыг сайжруулах нь
С.Оюунтуяа Сонгогчийн боловсрол төв	Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх нь
Н.Оюунчимэг Сонгогчийн боловсрол төв	Сонгуульт албан тушаалтныг эргүүлэн татах зохицуулалт



АОХН-ИЙН VII ЧУУЛГА УУЛЗАЛТ-ИРГЭНИЙ НИЙГМИЙН ФОРУМ

Монгол Улсын Засгийн газар Ардчилсан Орнуудын Хамтын Нийгэмлэгийн Сайд нарын VII чуулга уулзалтыг 2013 оны дөрөвдүгээр сарын 27-29-нд Улаанбаатар хотноо зохион байгуулсан билээ. Энэхүү олон улсын өндөр хэмжээний төлөөлөгчид оролцсон уулзалтын хүрээнд Иргэний нийгмийн, Эмэгтэйчүүдийн, Хүүхэд залуучуудын, Бизнесийн гэсэн дөрвөн салбар форум зохион байгуулагдаж тус бүрдээ зөвлөмж гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг Сайд нарын уулзалтаас батлан гаргасан тунхаглалд тусгалаа.

ННФ нь орон орны хүний эрх, ардчиллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын 113 төлөөлөгч оролцсон Иргэний нийгмийн форумын ерөнхий зохион байгуулагч, зохицуулагчаар ажиллав. Иргэний нийгмийн форумын оролцогчид засаглал, ардчиллын боловсрол, шинээр гарч буй ардчилсан орнуудад үзүүлэх дэмжлэг, авилгатай тэмцэх гэсэн үндсэн сэдвийн хүрээнд харилцан туршлага солилцов. Хурлын төгсгөлд 13 зүйл бүхий зөвлөмж баталж Сайд нарын нэгдсэн уулзалтад хүргүүлэв.

ННФ тус хурлын оролцогчдыг тодорхойлж урих, сэдэв агуулгыг хэлэлцэж тогтох гээд бүх талын бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн бөгөөд олон улсын нэр хүндтэй томоохон арга хэмжээг зохион байгуулах талаар ихээхэн туршлага хуримтлуулж, ардчилал засаглалын чиглэлээр ажилладаг олон тооны иргэний нийгмийн байгууллагатай харилцаа холбоо тогтоох боломж олдлоо.



*Иргэний нийгмийн форумын хуралдааны үйл ажиллагаа
Зүүн гар талаас: Хуралдааны явц, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, ННФ-ын Гүйцэтгэх захирал П. Эрдэнэжаргал,
НҮБ-ын Тайван хуран цуглах асуудал хариуцсан Тусгай илтгэгч Майна Кай*

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлгийн зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
<i>ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР</i>			
Хүний эрх	6,223	26,296	32,519
Шүүхийн хараат бус байдал	17,699	34,456	52,155
Нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах нь	18,310	13,097	31,407
Төрийн ил тод хариуцлагатай байдал, иргэний нийгмийн оролцоо	28,548	50,727	79,275
Байгаль орчны талаар мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулах нь	28,145	4,614	32,759
Чөлөөт шударга сонгууль	3,666	2,956	6,622
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	30,481	46,719	77,200
<i>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР</i>			
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал	82,697	43,015	125,712
Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ	7,000	38,607	45,607
Бизнесийн орчин		8,535	8,535
<i>НИЙГЭМ, БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР</i>			
Нийгмийн үйлчилгээний хүртээмж	36,991	-	36,991
Боловсролын үйлчилгээний хүртээмж	143,231	27,197	170,428
<i>ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ</i>			
ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ, ПОРТАЛ САЙТ		84,210	84,210
БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР	37,930	19,670	57,600
ЗАХИРГАА	-	443,894	443,894
НИЙТ ДҮН	440,921	843,993	1,284,914

ТЭТГЭЛГИЙН НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Байгууллагад олгосон	Хувь хүнд олгосон	Тэтгэлгийн зардал
<i>ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР</i>			
Хүний эрх	6,223	-	6,223
Шүүхийн хараат бус байдал	10,699	7,000	17,699
Нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах нь	18,310	-	18,310
Төрийн ил тод хариуцлагатай байдал, иргэний нийгмийн оролцоо	28,548	-	28,548
Байгаль орчны талаар мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулах нь	10,000	18,145	28,145
Чөлөөт шударга сонгууль	3,666	-	3,666
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	30,481	-	30,481
<i>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР</i>			
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал	74,794	2,000	82,697
Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ	-	7,000	7,000
Бизнесийн орчин	-	-	-
<i>НИЙГЭМ, БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР</i>			
Нийгмийн үйлчилгээний хүртээмж	36,991	-	36,991
Боловсролын үйлчилгээний хүртээмж	122,101	21,130	143,231
<i>ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ</i>			
ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ, ПОРТАЛ САЙТ		-	-
БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР		37,930	37,930
<i>ЗАХИРГАА</i>			
		-	-
НИЙТ ДҮН	341,813	93,205	440,921

2013 ОНД ОЛГОСОН НИЙТ ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ

\$ доллар

	Байршил	Тэтгэлэг хүртэгчийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн
1	Архангай	Хөдөөгийн Хөгжлийн Ундарга	ТББ	2,327
2	Баянхонгор	Хонгор Нутгийн Дуудлага	ТББ	8,715
3	Дорнод	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	2,418
4	Завхан	Ногоон Тэс	ТББ	5,454
5	Орхон	Олон Нийтийн Оролцоотой Хөгжлийн төв	ТББ	2,709
6	Орхон	Оюунлаг нийгэмлэг	ТББ	5,421
7	Өвөрхангай	Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны сан	ТББ	3,417
8	Төв	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	2,897
9	Төв	Ажил Олгогч Эздийн холбоо	ТББ	3,845
10	Ховд	Хэвлэлийн Хүрээлэн	ТББ	2,933
11	Улаанбаатар	Б.Пүрэвдорж-баг	баг	2,139
12	Улаанбаатар	Дашин Дэм	ТББ	2,133
13	Улаанбаатар	Дашин Дэм	ТББ	2,758
14	Улаанбаатар	Гэгээ Мандал	ТББ	3,092
15	Улаанбаатар	Мэдээлэл Шинжилгээ, Үнэлгээний төв	ТББ	3,241
16	Улаанбаатар	Нийгмийн Тусын Төлөө сан	ТББ	3,264
17	Улаанбаатар	МИДАС	ТББ	3,666
18	Улаанбаатар	Монголын Байгаль Хамгаалах Иргэний Хөдөлгөөнүүдийн эвсэл	ТББ	4,085
19	Улаанбаатар	Байгаль Орчин, Эрүүл Мэнд төв	ТББ	4,264
20	Улаанбаатар	Марал Элч Сан	ТББ	4,507
21	Улаанбаатар	Хүний Нөөц Нийгмийн Төлөвшил	ТББ	5,278
22	Улаанбаатар	Эрхэм Журам	ТББ	6,223
23	Улаанбаатар	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	6,898
24	Улаанбаатар	Хүүхэд Хамгааллын Үндэсний сүлжээ	ТББ	8,190
25	Улаанбаатар	Ариун Суварга хөдөлгөөн	ТББ	15,895 *
26	Улаанбаатар	Хөвсгөл Далайн Эзэд	ТББ	10,000
27	Улаанбаатар	Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний холбоо	ТББ	10,120
28	Улаанбаатар	Хүнсний Тусгаар Байдлын Төлөө Хүмүүсийн эвсэл	ТББ	10,699
29	Улаанбаатар	Ил Тод сан	ТББ	19,800
30	Улаанбаатар	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	ТББ	32,000
31	Улаанбаатар	Хил Хязгааргүй Алхам	ТББ	48,500

* 2014 оны 4 сард төслийн үлдэгдэл болох \$ 5903 буцаагдсан.

	Байршил	Тэтгэлэг хүртэгчийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн
32	Улаанбаатар	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	ТББ	90,101
33	Улаанбаатар	Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл Стратегийн Судалгааны хүрээлэн	Төрийн	10,727
34	Улаанбаатар	Л.Батжав	иргэн	1,450
35	Улаанбаатар	Д.Цэрэнжав	иргэн	1,615
36	Улаанбаатар	Ч.Энхбаяр	иргэн	1,615
37	Улаанбаатар	Ч.Ганцэцэг	иргэн	1,615
38	Улаанбаатар	Н.Байгальмаа	иргэн	1,615
39	Улаанбаатар	Д.Дулмаа	иргэн	1,615
40	Улаанбаатар	Г.Баярмаа	иргэн	1,615
41	Улаанбаатар	Б.Баярмаа	иргэн	1,725
42	Улаанбаатар	Д.Батболд	иргэн	1,725
43	Улаанбаатар	Б.Батболд	иргэн	2,000
44	Улаанбаатар	М.Алтанбагана	иргэн	3,200
45	Улаанбаатар	Ч.Алтангэрэл	иргэн	3,400
46	Улаанбаатар	С.Сэлэнгэ	иргэн	3,415
47	Улаанбаатар	Г.Ариун	иргэн	3,415
48	Улаанбаатар	С.Оюунтуяа	иргэн	3,500
49	Улаанбаатар	Н.Оюунчимэг	иргэн	3,500
50	Улаанбаатар	С.Билгүүн	иргэн	3,500
51	Улаанбаатар	Ц.Болортуяа	иргэн	3,500
52	Улаанбаатар	Ж.Алтайбаатар	иргэн	3,500
53	Улаанбаатар	Б.Золзаяа	иргэн	3,500
54	Улаанбаатар	А.Анударь	иргэн	3,500
55	Улаанбаатар	Д.Цэрэнжав	иргэн	3,500
56	Улаанбаатар	М.Ариунтунгалаг	иргэн	3,500
57	Улаанбаатар	Б.Гэрэлмаа	иргэн	3,500
58	Улаанбаатар	З.Базаргүр	иргэн	3,555
59	Улаанбаатар	Ө.Ганболд	иргэн	3,575
60	Улаанбаатар	Т.Энхтайван	иргэн	3,575
61	Улаанбаатар	Б.Болормаа	иргэн	3,575
62	Улаанбаатар	Д.Дэлгэрмаа	иргэн	3,575
63	Улаанбаатар	Ц.Эрдэнэчимэг	иргэн	4,080
64	Улаанбаатар	Н.Нарангэрэл	иргэн	6,250
НИЙТ ДҮН				440,921



АЖИЛТНУУД

Нээлттэй Нийгэм Форумын Удирдах Зөвлөлийн гишүүд

Г. Уранцоож	УЗ-ийн дарга, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн
Т. Ундарьяа	УЗ-ийн гишүүн, МОНФЕМНЕТ сүлжээний зохицуулагч
Ж. Үнэнбат	УЗ-ийн гишүүн, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-ын гүйцэтгэх захирал
Ч. Хашчулуун	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн ЭЗС-ийн багш
Ч. Лодойравсал	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн МТС-ийн захирал
Ц. Отгонбаатар	УЗ-ийн гишүүн, ЛГБТ төвийн захирал
О. Энхтуяа	УЗ-ийн гишүүн, Дэ Нэйчэр консерванси ТББ-ын захирал

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

П. Эрдэнэжаргал	jargal@forum.mn
-----------------	-----------------

Нээлттэй Нийгэм Форумын ажилтнууд

П. Бадамрагчаа	Засаглалын хөтөлбөр хариуцсан менежер	badmaa@forum.mn
Ж. Оюунтүлхүүр	Засаглалын хөтөлбөр хариуцсан менежер	oyuna@forum.mn
Б. Хишигсайхан	Засаглалын хөтөлбөр хариуцсан менежер	khishgee@forum.mn
Б. Цолмон	Засаглалын хөтөлбөр хариуцсан менежер	tsolmon@forum.mn
Н. Дорждарь	Эдийн засгийн хөтөлбөр хариуцсан менежер	dorjdari@forum.mn
Б. Мөнхсоёл	Эдийн засгийн хөтөлбөр хариуцсан менежер	(2013 оны 7 сар хүртэл)
Д. Оюунбадам	Эдийн засгийн хөтөлбөр хариуцсан менежер	oyunbadam@forum.mn
А. Гэрэлмаа	Нийгэм, Боловсролын хөтөлбөр хариуцсан менежер	gerelmaa@forum.mn
О. Сэлэнгэ	Хөтөлбөрийн туслах ажилтан	passistant@forum.mn
Б. Үүрийнтуяа	Хөтөлбөрийн туслах ажилтан	fellowship@forum.mn
Д. Балжид	Мэдээллийн менежер	baljid@forum.mn
Д. Баярмаа	Мэдээллийн ажилтан	dircassist@forum.mn
Д. Жавхлан	Санхүүгийн захирал	javkhlan@forum.mn
Д. Аюуш	Оффис, тэтгэлгийн менежер	ayush@forum.mn
Г. Одонмижид	Нягтлан бодогч	odnoo@forum.mn
Э. Сайнтүвшин	Мэдээлэл сүлжээний зохицуулагч	sainaa@forum.mn
Д. Ганзул	Захирлын туслах	reception@forum.mn
Б. Баатар	Захиргааны ажилтан	baatar@forum.mn
Г. Цэдэвхүү	Захиргааны ажилтан	tsedev@forum.mn
С. Солонго	Захиргааны ажилтан	solongo@forum.mn

Нийтлэг И-мэйл: osf@forum.mn

